САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ

2022 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛ

АГУУЛГА

I. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн зах зээлийн төлөв 8
Хүртээмжтэй байдал 10
Бүтээгдэхүүн үйлчилгээ 12
Ашигт ажиллагаа 15
Тогтвортой байдал 18
Бодлого зохицуулалт 19

II. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн зах зээлийн төлөв 22
Хүртээмжтэй байдал 26
Бүтээгдэхүүн үйлчилгээ 29
Ашигт ажиллагаа 31
Тогтвортой байдал 32
Бодлого зохицуулалт 33

III.БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Санхүүгийн зах зээлийн төлөв 36
Хүртээмжтэй байдал 41
Бүтээгдэхүүн үйлчилгээ 44
Ашигт ажиллагаа 48
Тогтвортой байдал 50
Бодлого зохицуулалт 52

IV. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Санхүүгийн зах зээлийн төлөв 56
Хүртээмжтэй байдал 58
Бүтээгдэхүүн үйлчилгээ 62
Ашигт ажиллагаа 66
Тогтвортой байдал 68
Бодлого зохицуулалт 70

V. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Санхүүгийн зах зээлийн төлөв 74
Хүртээмжтэй байдал 75
Бүтээгдэхүүн үйлчилгээ 77
Ашигт ажиллагаа 78
Тогтвортой байдал 79

VI. СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Зохицуулалтын орчны төлөв 81
Сэндбоксод туршигдаж буй бүтээгдэхүүнүүд 81

VII. ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ

Салбарын төлөв 84

VIII. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ

Салбарын төлөв 88
Хүртээмжтэй байдал 89
Бүтээгдэхүүн үйлчилгээ 90
Бодлого зохицуулалт 93

IX. ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

Салбарын төлөв 96
Хүртээмжтэй байдал 97
Бүтээгдэхүүн үйлчилгээ 98
Бодлого зохицуулалт 99

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХБ	Азийн хөгжлийн банк
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ
МИК	Монголын ипотекийн корпораци
МХЗХҮХ	Монголын хадгаламж, зээлийн хоршооны үндэсний холбоо
МХБ	“Монголын хөрөнгийн бирж” ХК
МҮЦБ	“Монголын үнэт цаасны бирж” ХК
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ТДЦА	Татварын дараах цэвэр ашиг
ТЗК	Тусгай зориулалтын компани
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци
УҮГ	Улсын үйлдвэрийн газар
ҮХЭХБХСЗ	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлал
ҮХЭХЗ	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал
ҮЦК	Үнэт цаасны компани
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ХААБ	Хөдөө аж ахуйн бирж
ХЖДХ	Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
ХК	Хувьцаат компани
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
МАРІХ	Монголын хөдөө аж ахуйн барааны үнийн индекс
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
AFI	Alliance for Financial Inclusion / Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг/
ATM	Automated teller machine /Автомат теллер машин/
ESG	Environmental, Social, Governance /Байгаль орчин, нийгэм, засаглал/
JICA	Japan International Cooperation Agency /Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага/
IAIS	International Association of Insurance Supervisors /Олон улсын даатгалын зохицуулагчдын холбоо/
IPO	Initial public offering /Олон нийтэд хувьцаагаа санал болгох/
FPO	Follow up on public offering /Нэмэлт хувьцаа гаргах/
MSE	Mongolian stock exchange /Монголын хөрөнгийн бирж/
UNEP FI	Нэгдсэн үндэсний байгууллагын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүжилтийн санаачилга


ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ
Зах зээлийн үнэлгээ 4,788.3 тэрбум төгрөг
ЗЗҮ/ДНБ 11.1%
Нийт хөрөнгө 449.6 тэрбум төгрөг
ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ
ТОП–20 индекс 34,024.26
Арилжааны дүн 328.4 тэрбум төгрөг
Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж 219.8 тэрбум төгрөг
Даатгалын нөхөн төлбөр 68.9 тэрбум төгрөг
ХК–ийн тоо 314
Хөрвөх чадвар 2.7%
Цэвэр ашиг 14.1 тэрбум төгрөг
Нөөц сан 209.0 тэрбум төгрөг
MSE A 12,098.54
MSE B 11,972.15
ХАА–н гаралтай барааны арилжааны хэмжээ 1,034.2 тэрбум төгрөг
Даатгалын компанийн тоо 17
Нягтрал 73,462 төгрөг
Давхар даатгалын хураамжийн зардал 68.3 тэрбум төгрөг
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА
Тусгай зөвшөөрөлтэй 522 ББСБ
92.7 % Зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй
Тусгай зөвшөөрөлтэй 202 ХЗХ
ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО
Нийт хөрөнгө 3.4 их наяд төгрөг
4.9 сая Харилцагч
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 3.6%
72,770 гишүүн
Нийт хадгаламж 189.8 тэрбум төгрөг
Цэвэр ашиг 7.5 тэрбум төгрөг
Нийт зээл 2.7 их наяд төгрөг
Нийт зээлдэгч 1.6 сая
Нийт хөрөнгө 266.7 тэрбум төгрөг
НИЙТ ЗЭЭЛ 216.1 тэрбум төгрөг
Зээлийн жигнэсэн дундаж хүү 3.1%
Нийт орлого 624.8 тэрбум төгрөг
Хүүгийн орлого 500.6 тэрбум төгрөг
2.4% Зээлийн жигнэсэн дундаж хүү
1.2% Хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү
ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ
ҮХЭХЗ–ын байгууллага 295
Иргэн 456
Хуулийн этгээд 45
ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУ
5 Төрлийн үйлчилгээ
86.1 тэрбум төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийг зуучлан түрээслүүлэв
Үнэт металл худалдан авалт 216.4 тэрбум төгрөг
Үнэт металлын борлуулалт 213.3 тэрбум төгрөг

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн үнэлгээ

4,788.3

тэрбум төгрөг

Санхүүгийн зах зээлийн төлөв

Дансны тоо

2,439,127

Хүртээмжтэй байдал

Нийт арилжааны дүн

328.4 тэрбум төгрөг

Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа

ҮЦК–ийн хөрөнгө

179.5

тэрбум төгрөг

Улсад татан төвлөрүүлсэн татвар, НДШ (ҮЦК, ХОМК)

2.6

тэрбум төгрөг

Тогтвортой байдал

ТОП–20 индексийн хэлбэлзэл

2,973.3

Бодлого зохицуулалт

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

Үнэт цаасны зах зээлд нийт **586** зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байна

Арилжаа эрхлэх **2**	Төвлөрсөн хадгаламж, үнэт цаасны арилжааны төлбөрийн **1**	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэл хянагч **1**
ХОМК **36**	Тооцооны **2** /давхардсан/	Кастодиан **3**
Андеррайтерийн зөвшөөрөлтэй банк **2**	Хөрөнгө итгэмжлэн удирдах **7**	ХК **314**
ҮЦК* **53**	ХАА түүхий эдийн арилжаа эрхлэх **1**	ХАА түүхий эдийн брокер **10**
ҮЦЗЗ-д аудитын үйлчилгээ үзүүлэх **45**	ҮЦЗЗ-д хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх **24**	ҮЦЗЗ-д хуулийн үйлчилгээ үзүүлэх **35**
Хамтын хөрөнгө оруулалтын сан **4**	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч **46 /ТЗК/**	Өөрийгөө зохицуулах байгууллага **2** /давхардсан/

Хувийн хөрөнгө оруулалтын сан (Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 5.3 дахь заалт) **29**

**ҮЦК-д брокер, дилер, андеррайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагыг хамаатуулна.*

Үнэт цаасны арилжаа /тэрбум төгрөг/



Үнэт цаасны зах зээлийн арилжаа

- 2022 оны 3 дугаар улиралд нийт 328.4 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжаалагдсан бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 818.9 тэрбум төгрөгөөр буюу 71.4 хувиар буурсан бол, 2018 оны мөн үеэс 3.1 дахин өссөн үзүүлэлт юм.
- Нийт арилжааны 32.0 хувийг компанийн бондын, 1.0 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн, 21.2 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны, 45.8 хувийг хувьцааны арилжаа тус тус эзэлж байна.

Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар

- Нийт зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.7 хувиар буурч 4.8 их наяд төгрөгт хүрсэн бол хөрвөх чадвар 1.0 пунктээр буурч 2.7 хувьд хүрлээ.



ЗЗҮ/ДНБ /хувиар/



Эх сурвалж: www.worldbank.org

- Монголын Үнэт цаасны зах зээлийн үнэлгээг ДНБ–д харьцуулсан дүнг FTSE жагсаалтад багтах фронтиер зах зээлийн улс орнуудтай харьцуулахад 3 дугаарт жагсаж байна.

ШИГТГЭЭ

FTSE Russell группээс 2022 оны 09 дүгээр сарын 29–ний өдөр Монгол Улсыг Хөгжиж буй зах зээл (Frontier Market) ангилалд албан ёсоор оруулаа.

ТОП 20 34,024.26

MSE A 12,098.54

MSE B 11,972.15

Үнэт цаасны зах зээлийн индекс

- ТОП–20 Индекс өмнөх оны мөн үеэс 8,913.00 нэгжээр буюу 20.8 хувиар буурсан.
- MSE А индекс өмнөх оны мөн үеэс 1,873.92 нэгжээр буюу 13.4 хувиар буурсан.
- MSE Б индекс өмнөх оны мөн үеэс 298.35 нэгжээр буюу 2.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ХААБ–ээр нийт 5 төрлийн 1,034.2 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 362.0 тэрбум төгрөгөөр буюу 53.9 хувиар өссөн үзүүлэлт юм.



ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ТОП–20 ИНДЕКСЭД БАГТАХ ХК–УУДЫН САЛБАРЫН АНГИЛАЛ /ЗЗҮ–ЭЭР/

АЖ ҮЙЛДВЭР **56.3%**

БАНК САНХҮҮ **19.7%**

УУЛ УУРХАЙ **17.4%**

ХАРИЛЦАА ХОЛБОО **4.4%**

ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ **2.2%**

ХУВЬЦААНЫ ТӨВЛӨРӨЛ

- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29–д "нөлөө бүхий хувьцаа эзэмшигч" гэж тухайн компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны тав болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээд гэж заасан байдаг.
- ТОП–20 индексэд ХК–уудын төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй буюу нийт хувьцааны 80.3 хувийг нийт хувьцаа эзэмшигчдийн 0.05 хувь нь эзэмшиж байна.

5–аас дээш хувь эзэмшигч

Хувьцааны **80.3%** хувийг **0.05%** нь эзэмшиж байна

5–аас доош хувь эзэмшигч

Хувьцааны **19.7%** хувийг **99.95%** нь эзэмшиж байна

НЭЭГДСЭН ДАНСНЫ ТОО



- Шинээр 10,406 данс, 37,137 холболтын данс нээгдэж, нийт дансны тоо 2,439,127, холболтын дансны тоо 501,213–д хүрлээ.

НИЙТ ДАНСНЫ ТОО /ӨССӨН ДҮНГЭЭР/

2,439,127

ҮЦТХТ–Д БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС

МХБ–д бүртгэлтэй хувьцаа
17,052,887,143

МХБ болон МҮЦБ–д бүртгэлтэй бонд
7,024,816

Хаалттай хүрээнд бүртгэлтэй хувьцаа
74,003,439,467

МҮЦБ–д бүртгэлтэй хувьцаа
78,070,758

Хаалттай хүрээнд бүртгэлтэй бонд
24,475,682,657

НИЙТ
115,617,104,841

ҮЦК БОЛОН ХАА–Н БРОКЕРЫН КОМПАНИУДЫН БАЙРШИЛ

- Улаанбаатар хотод нийт 53 ҮЦК болон тэдгээрийн 40 салбар орон нутагт үйл ажиллагаа явуулав.
- Нийт 10 ХАА–н брокер үйл ажиллагаа явуулж байгаагийн 7 нь Улаанбаатар хотод, 3 нь орон нутагт байршиж байна.

ЧИНГЭЛТЭЙ		СҮХБААТАР	СОНГИНО ХАЙРХАН
ҮЦК	ХАА–Н БРОКЕР	ҮЦК	ХАА–Н БРОКЕР
15	5	25	2

ХАН–УУЛ	БАЯНЗҮРХ	БАЯНГОЛ
ҮЦК	ҮЦК	ҮЦК
3	6	4

САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧИД

БАРУУН БҮС		ХАНГАЙН БҮС	ТӨВИЙН БҮС	ЗҮҮН БҮС	
ҮЦК	ХАА–Н брокер	ҮЦК	ҮЦК	ҮЦК	ХАА–Н брокер
6	2	14	17	3	1

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

- 2022 оны 3 дугаар улиралд нийт хувьцааны арилжаа 150.4 тэрбум төгрөгт хүрсэн нь 2018 оны мөн үеэс 2 дахин өссөн бол өмнөх оны мөн үеэс 19.2 хувиар буурчээ.



КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖАА

- 2022 оны 3 дугаар улиралд компанийн бондын арилжаа 105.1 тэрбум төгрөгт хүрсэн нь 2018 оны мөн үеэс 166.5 дахин өссөн бол өмнөх оны мөн үеэс 8.6 дахин буурчээ.



ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлд нийт 65.0 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлд нийт 4.7 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийгдсэн.
- Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох зорилгоор 2013 оноос ипотекийн бага хүүтэйгээр орон сууцны зээлийг иргэдэд олгож эхэлсэн. Өнөөгийн байдлаар “МИК ОССК” ХХК–аас үүсгэн байгуулсан 29 ТЗК–ийн хүрээнд нийт 94,309 зээлдэгчийн ипотекийн зээлийг үнэт цаасжуулж 5.4 их наяд төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг СЗХ–нд бүртгүүлээд байгаа бол 2022 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 65,410 зээлдэгчийн 3.4 их наяд төгрөгийн баталгаат үнэт цаасны үлдэгдэлтэй байна.
- Монголбанкны мөнгөний бодлогын хорооны 2020.09.14–ний өдрийн хурлын 5 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт уул уурхайн бус экспортын салбарын болон жижиг, дунд үйлдвэрлэгчид олгосон төгрөгийн хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас барьцаалсан Монголбанкны репо арилжааны хэмжээг 2020 оны 4 дүгээр улиралд 230.0 тэрбум төгрөгөөс илүүгүй байхаар тогтоож өгсөн бөгөөд үүнтэй холбогдуулан “Үнэт цаасны санхүүжилтийн корпораци” ХХК–аас дээрх шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зориулалтын компанийг үүсгэн байгуулж ажиллаж байна. Өнөөгийн байдлаар тус копаниас 4 ТЗК үүсгэн байгуулж, уул уурхайн бус экспортын салбарын болон жижиг, дунд үйлдвэрлэгчид олгосон нийт 2,298 зээлийг багцлан 538.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргаад байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН АРИЛЖАА

- Хөрөнгө оруулалтын сангийн 3.1 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан нь өмнөх оны мөн үеэс 17.3 дахин буурсан байна.

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН

ХААЛТТАЙ БОЛОН НЭЭЛТТЭЙ ХҮРЭЭНД ГАРСАН ХУВЬЦАА /ТЭРБУМ ТӨГРӨГ/

Гаргасан компани	Бүртгэсэн огноо	Татан төвлөрүүлсэн дүн
ХААЛТТАЙ		
“Шарын гол” ХК–ийн өрийг хувьцаагаар солих зорилгоор хаалттай хүрээнд гаргасан энгийн хувьцаа	2022.01.26	0.2
“Блюскай секьюритиз ҮЦК” ХК–ийн хаалттай хүрээнд нэмж гаргасан энгийн хувьцаа	2022.03.09	0.6
“Тандэм инвест ББСБ” ХК–ийн хаалттай хүрээнд нэмж гаргасан энгийн хувьцаа	2022.06.08	0.9
IPO		
“Эрдэнэс сольюшинс” ХК–ийн нийтэд санал болгон нэмж гаргаж буй хувьцаа	2022.05.25	1.9
“Инвескор ББСБ” ХК–ийн нийтэд санал болгон нэмж гаргаж буй хувьцаа	2022.06.08	16.7
“Мон бийф” ХК–ийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцаа	2022.06.22	2.9
“Сэндли ББСБ” ХХК–ийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцаа	2022.08.10	10.5
“Төрийн банк” ХХК–ийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцаа	2022.09.21	25.4

КОМПАНИЙН ХААЛТТАЙ ӨРИЙН ХЭРЭГСЭЛ /ТЭРБУМ ТӨГРӨГ/

Гаргасан компани	Бүртгэсэн огноо	Татан төвлөрүүлсэн дүн
“Ард кредит ББСБ” ХК	2022.03.09	7.0

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС /ТЭРБУМ ТӨГРӨГ/

Бодлогын баримт бичиг	Үнэт цаас гаргагч	Бүртгэсэн огноо	Хөрөнгийн тоо	ХБҮЦ дүн
“Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох” хөтөлбөрийн хүрээнд	“МИК актив хорин ес” ХХК	2022.07.06	7,309	532.8
УИХ–ын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”–ийн хүрээнд	“ҮЦСК актив гурав ТЗК” ХХК	2022.06.22	712	217.6
	“ҮЦСК актив дөрөв” ХХК	2022.09.21	325	111.8

НЭЭЛТТЭЙ ХБҮЦ /ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР/

Үнэт цаас гаргагч	Бүртгэсэн огноо	Хугацаа	Хүү	Татан төвлөрүүлсэн дүн
“Омни актив ТЗК” ХХК	2022.01.12	24 сар	14.5%	5.0
“Симпл ассет” ХХК	2022.06.08	18 сар	15.0%	50.0
“Бэрс Эй Би Эс актив ТЗК” ХХК	2022.08.10	24 сар	16.8%	10.0
“Нөмөр кредит ассет ТЗК” ХХК	2022.09.21	24 сар	17.5%	10.0
“ЛэндМН актив ТЗК” ХХК	2022.09.21	24 сар	17.0%	4.9

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН /ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР/

ХОМК	Зөвшөөрөл олгосон он	Сангийн нэр	Татан төвлөрүүлсэн дүн
“Мандал ассет менежмент ҮЦК” ХХК	2022.05.11	Мандал хуримтлал хамтын ХОС	100.0
“Ард менежмент ҮЦК” ХХК	2022.05.11	Хөрөнгө оруулагч үндэстэн хамтын ХОС	3.0

ШИГТГЭЭ

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс хойш 2022 оны 3 дугаар улирлын байдлаар биржийн бус зах зээлд нийт 54 үнэт цаас гаргагчийн 67 компанийн бонд гарсан бөгөөд 681.7 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна.

АРИЛЖААНЫ БҮТЭЦ /ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДААР/

- Арилжаанд оролцогчдын дийлэнх хувийг дотоодын иргэн эзэлж байгаа бөгөөд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар дотоодын иргэний хийсэн арилжааны гүйлгээ 52.9 хувийг, дотоодын ААН–ийн хийсэн арилжааны гүйлгээ 43.7 хувийг тус тус эзэлж байна. Харин гадаадын ААН–ийн хийсэн арилжааны гүйлгээ 1.2 хувийг, гадаадын иргэний хийсэн арилжааны гүйлгээ 2.2 хувийг эзэлж байна.



- Дотоодын ААН, 43.7%
- Гадаадын ААН, 1.2%
- Дотоодын иргэн, 52.9%
- Гадаадын иргэн, 2.2%

ХУВЬЦААНЫ ӨМЧИЙН БҮТЭЦ

- 2022 оны 3 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны бүртгэлд нийт 314 ХК бүртгэлтэй байна.
- Өмчийн бүтцийг задлан харвал нийт ХК–ийн 85.6 хувь нь хувийн өмчит, 11.2 хувь нь төрийн өмчит, 3.2 хувь нь төрийн өмчийн оролцоотой байна.



- Хувийн өмчит 85.6%
- Төрийн өмчит 11.2%
- Төрийн өмчит оролцоотой 3.2%

АШИГТ АЖИЛЛАГАА



ҮЦК–ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

- ҮЦК–уудын нийт хөрөнгө 2022 оны 3 дугаар улиралд 179.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 50.6 хувиар өссөн үзүүлэлт юм.
- 2021 оны 3 дугаар улиралтай харьцуулахад орлого 13.0 тэрбум төгрөгөөр, зарлага 9.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн ба 2.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

ҮЦК–ИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ

Брокерын үйл ажиллагааны орлого	24.2%
Дилерийн үйл ажиллагааны орлого	4.7%
Андеррайтерийн үйл ажиллагааны орлого	39.2%
Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааны орлого	6.4%
Үнэт цаасны арилжааны цэвэр орлого	3.0%
Бусад үйл ажиллагааны орлого	2.0%
Түрээсийн орлого	4.4%
Хүүний орлого	0.0%
Ногдол ашгийн орлого	9.9%
Бусад орлого	0.6%
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	0.6%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	5.0%



ҮЦК–ИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ

- Борлуулалтын маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал
- Санхүүгийн зардал
- Орлогын татварын зардал
- Бусад зардал



- Үнэт цаасны компаниуд тайлант улиралд НДШ–д 0.8 тэрбум төгрөг, ХХОАТ–т 0.3 тэрбум төгрөг, ААН–ийн орлогын албан татварт 0.7 тэрбум төгрөгийг тус тус төлж, нийт улсын төсөвт 1.8 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд байна.

ХОМК–ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ХОМК–ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

- ХОМК–уудын нийт хөрөнгө 2022 оны 3 дугаар улиралд 70.5 тэрбум төгрөгт хүрсэн.
- 2021 оны 3 дугаар улиралтай харьцуулахад зарлага 0.7 тэрбум төгрөгөөр өсөж 1.9 тэрбум төгрөгийн цэвэр алдагдалтай ажилласан байна.

ХОМК–ИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ



ХОМК–ИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ



- Хөрөнгө оруулалт менежментийн компаниуд тайлант улиралд НДШ–д 0.6 тэрбум төгрөг, ХХОАТ–т 0.2 тэрбум төгрөг, ААН–ийн орлогын албан татварт 0.1 тэрбум төгрөгийг тус тус төлж, нийт улсын төсөвт 0.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд байна.

ХААБ-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



КАСТОДИОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



КАСТОДИАНЫ ХАРИЛЦАГЧДЫН БҮТЭЦ

- Кастодиан банкны харилцагчдын дийлэнх хувийг дотоодын иргэн эзэлж байгаа бөгөөд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар нийт харилцагчдын 92.6 хувийг дотоодын иргэн, 5.9 хувийг дотоодын ААН, 0.8 хувийг гадаадын иргэн, 0.7 хувийг гадаадын ААН тус тус эзэлж байна.



- Кастодиан банканд хадгалагдаж буй хөрөнгийг ангилан үзвэл 97 хувийг харилцагчдын эзэмшиж буй үнэт цаас, 2.5 хувийг ХБҮЦ, 0.4 хувийг үл хөдлөх хөрөнгө, үлдсэн 0.1 хувийг мөнгөн хөрөнгө тус тус эзэлж байна.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ТОП–20 ИНДЕКСИЙН ХЭЛБЭЛЗЭЛ

- Хувьцаааны үнийн хэлбэлзлийг ТОП–20 индексийн хүрээнд тооцоход 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 2,973.29 нэгж байгаа нь өмнөх оны мөн үеэс 3,845.26 пунктээр буурсан үзүүлэлт юм.





MSE А БОЛОН MSE Б ИНДЕКСИЙН ХЭЛБЭЛЗЭЛ

- Хувьцаааны үнийн хэлбэлзлийг MSE А болон MSE В индексүүдийн хувьд тооцож үзэхэд 2022 оны 3 дугаар улиралд MSE А индексийн хэлбэлзэл 303.4пунктээр, MSE В индексийн хэлбэлзэл 1,365.2 нэгжээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

IPO ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ

- 2005 оноос 2022 оны 3 дугаар улирал хүртэл нийт 28 компани IPO хийж нийт 227.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг анхдагч зах зээлээс татан төвлөрүүлсэн байна.

FPO ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ

- Монголын анхны Follow on Public Offering (FPO) буюу нэмж хувьцаа гаргах замаар хөрөнгө татан төвлөрүүлэх арилжаа 2007 онд явагдаж байв.
- 2007 оноос хойш 2022 оны 3 дугаар улирал хүртэл давхардсан тоогоор 12 компани 13 удаагийн арилжаагаар нийт 62.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг нэмэлт хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлжээ.

КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

- Монголд бондын анхдагч зах зээлийн арилжаа анх 2001 онд явагдаж байв. 2001 оноос хойш 2022 оны 3 дугаар улирал хүртэл давхардсан тоогоор 18 компани 29 удаагийн арилжаагаар нийт 751.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүллээ.

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Монгол Улсын хөрөнгийн зах зээл олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч Их Британийн FTSE Russell компаниас тогтоодог “Хөгжиж буй зах зээл” /Frontier market/ ангиллын “Ажиглалтын жагсаалт”–д 2012 онд орсон хэдий ч 2017 оны 9 дүгээр сард FTSE Russell компанийн Засаглалын зөвлөлийн хурлын шийдвэрээр дэд бүтэц бүрэн хөгжөөгүй шалтгааны улмаас ажиглалтын жагсаалтаас хасагдаж байсан.
- Улмаар Санхүүгийн зохицуулах хороо, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд болон мэргэжлийн оролцогч байгууллагууд бэлтгэл ажлыг ханган системийн хэмжээнд үнэт цаасны дараа төлбөр тооцооны горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг 2020 оны 3 дугаар сард амжилттай шилжсэнээр манай улсын үнэт цаасны төлбөр тооцооны горим олон улсын жишигт нийцэж, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох нөхцөл бүрдсэнээр 2021 оны 9 дүгээр сарын 30–ны өдөр FTSE Russell–с Монгол Улсыг Хөгжиж буй зах зээл (Frontier market) ангиллын “Ажиглалтын жагсаалт”–д эргэн оруулсан ба 2022 оны 9 дүгээр сарын 29–ний өдөр FTSE Russell группээс Хөгжиж буй зах зээл (Frontier Market) ангилалд албан ёсоор орсон талаар мэдээлсэн.
- FTSE Russell–с гаргадаг энэхүү ангилалд Монгол Улс орсноор манай улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч, мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг татах, зах зээлийн арилжааны идэвх, хөрвөх чадварыг нэмэгдүүлж, хөгжлийг хурдасгах нөхцөл бүрдэх чухал ач холбогдолтой юм.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Санхүүгийн зохицуулах хорооноос “Үнэт цаасны бүртгэлийн журам”–ын нэмэлт өөрчлөлтөөр хувьцаат компани хааллтай хүрээнд нэмж хувьцаа гаргахтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулж, үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлж буй хууль, аудитын компаниудад тавигддаг шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж 2022 оны 7 дугаар сарын 06–ны өдрийн 378 дугаар тогтоолоор баталлаа.
- Улсын Их Хурлаас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2022.04.29–ний өдөр баталсан. Тус хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах, эрх зүйн орчныг бий болгох хүрээнд “Төрийн болон орон нутгийн өмчит нэлттэй хувьцаат компанийн хувьцааг эзэмшихтэй холбоотой хуульд заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавих журам”–ыг боловсруулсан ба олон нийтээс санал аваад байна.
- УИХ–аас Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2021 онд баталсны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 9 дүгээр сарын 21–ний өдрийн 505 дугаар тогтоолоор “Төрийн банк” ХХК–ийн нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг бүртгэснээр системийн нөлөө бүхий банкнуудаас нэлттэй хувьцаат компани болсон анхны банк боллоо.
- Энэ хүрээнд тухайн эдийн засгийн нэг салбарыг дагнасан мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хамтын хөрөнгө оруулалтын сангуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, банкны салбарын реформын хүрээнд банкнуудад хөрөнгө оруулалт хийх боломжийг өсгөх хэрэгцээ, шаардлагын улмаас Санхүүгийн зохицуулах хорооны 275 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”–д нэмэлт, өөрчлөлтийг тусгаж, олон нийтээс санал аваад байна.

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Нийт хөрөнгө

449.6 тэрбум төгрөг

Хөрөнгийн өсөлт **1.1%**

Санхүүгийн зах зээлийн төлөв

Даатгалын нягтрал

73,462 төгрөг

Нягтралын өсөлт

20.2%

Хүртээмжтэй байдал

Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж

219.8 тэрбум төгрөг

Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа

Цэвэр ашиг

14.1

тэрбум төгрөг

Улсад татан төвлөрүүлсэн татвар, НДШ

12.0

тэрбум төгрөг

Давхар даатгалд төлсөн хураамж

31.6%

Тогтвортой байдал

Бодлого зохицуулалт

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр нийт 321 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, актуарч, аудитор мөн 2,298 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа эрхэлж байна.

- Ердийн даатгалын компани 15
- Урт хугацааны даатгалын компани 1
- Давхар даатгалын компани 1
- Даатгалын зуучлагч компани 62
- Даатгалын хохирол үнэлэгч компани 25
- Даатгалын төлөөлөгч 2,298

- Аудитын компани 40
- Аудитор 137
- Актуарч 40



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ

- Нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.1 хувиар өсөж 449.6 тэрбум төгрөгт хүрсэн бол 2018 оны мөн үетэй харьцуулахад 37.2 хувиар өсжээ.
- Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ бусад даатгалын төрөлтэй харьцуулахад өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар өсөж 379.3 тэрбум төгрөгт хүрч, салбарын нийт хөрөнгийн 84.4 хувийг бүрдүүлж байна.
- Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.8 хувиар өсөж 10.1 тэрбум төгрөгт хүрч, салбарын 2.2 хувийг эзэлж байна.
- Давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.0 хувиар бууруч, 60.2 тэрбум төгрөг хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 13.4 хувийг эзэлж байна.

ХӨРӨНГИЙН БҮТЭЦ БА ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ /НИЙТ ХӨРӨНГӨӨР/

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн бүтцийг авч үзвэл 28.6 тэрбум төгрөг буюу 6.3 хувийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, 260.2 тэрбум төгрөг буюу 57.9 хувийг хөрөнгө оруулалт, 33.1 тэрбум төгрөг буюу 7.4 хувийг үндсэн ба биет бус хөрөнгө /цэвэр дүн/, 127.7 тэрбум төгрөг буюу 28.4 хувийг бусад хөрөнгө тус тус бүрдүүлж байна.

Даатгалын компаниудыг нийт хөрөнгөд эзэлж буй хувиар нь авч үзвэл 9 хувиас дээш хувийг 2 даатгалын, 6–9 хувийг 6 даатгалын, 3–6 хувийг 3 даатгалын, 3 хувиас доош хувийг 6 даатгалын компани бүрдүүлж байна.

Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь



ДААТГАЛЫН КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН ӨСӨЛТИЙН ТАРХАЛТ

Нийт даатгалын компаниудын хөрөнгийн дундаж өсөлт 2021 оны 3 дугаар улирлын байдлаар 10.9 хувь байсан бол тайлант улирлын байдлаар 5.5 хувьтай байна. Харин хөрөнгийн өсөлтөөр бүлэглэвэл 30–аас дээш хувийн өсөлттэй 2, 20–30 хувийн өсөлттэй 2, 10–20 хувийн өсөлттэй 2, 0–10 хувийн өсөлттэй 6, хөрөнгийн хэмжээ буурсан 5 даатгалын компани байна.

2020.III–2021.III / 2021.III–2022.III

Хөрөнгийн хэмжээ буурсан	10%–с доош	10% –20%	20% – 30%	30%–с дээш
4 | 5	5 | 6	3 | 2	1 | 2	3 | 2



НИЙТ ХУРААМЖ

- Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт 216.3 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлжээ.

Үүнээс: ердийн даатгалын компаниуд 214.2 тэрбум төгрөг буюу 99.0 хувь, урт хугацааны даатгалын компани 2.1 тэрбум төгрөг буюу 1.0 хувийг бүрдүүлжээ.

- Нийт хураамжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.7 хувиар, 2018 оны мөн үетэй харьцуулахад 73.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ДАВХАР ДААТГАЛД ТӨЛСӨН ХУРААМЖ

- Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт хураамжийн орлогын 68.3 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид төлсөн. Үүний 3.5 тэрбум төгрөг буюу 5.1 хувийг дотоодын давхар даатгагчид төлжээ.

ДААТГАЛЫН БОЛОН ДАВХАР ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

- Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 68.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 53.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин 2018 оны мөн үетэй харьцуулахад 63.3 хувиар өсжээ. Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 98.7 хувийг бүрдүүлжээ.
- Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн дүн 3.3 дахин өсөж 7.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.



НӨӨЦ САН

- Даатгалын салбарын нийт нөөц сангийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1 хувиар өсөж 209.0 тэрбум төгрөгт хүрсэн.
- Ердийн даатгалын компаниудын нийт нөөц сангийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 хувиар буурч 174.8 тэрбум төгрөгт хүрсэн бол, урт хугацааны даатгалын компанийн нөөц сан 34.8 хувиар өсөж 3.1 тэрбум төгрөг, давхар даатгалын компанийн нөөц сан 12.7 хувиар өсөж 31.1 тэрбум төгрөг болов.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ДААТГАЛЫН НЯГТРАЛ

Даатгалын нягтралын үзүүлэлт буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь салбарын хүртээмж, эрэлтийг илэрхийлдэг. Хүн амын тоог жилд нэг удаа тооцдог тул даатгалын нягтралыг улирлаар тооцох боломжгүй юм.



- Даатгалын нягтрал 2021 онд 73,462 төгрөг болж 2020 онтой харьцуулахад 20.2 хувиар, 2017 онтой харьцуулахад 63.8 хувиар тус тус өссөн байна.
- Даатгалын нягтралыг ангиллаар авч үзвэл, нэг хүнд ногдох ердийн даатгалын хураамж 20.2 хувиар өсөж 72,921 төгрөг болсон бол урт хугацааны даатгалын хураамж 20.6 хувиар өсөж 541 төгрөгт хүрсэн.

ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ТОО

Нийт 1,074,358 даатгалын гэрээ байгуулагдсан байна. Үүний 82.0 хувь буюу 881,278 хувь хүнтэй, 18.0 хувь буюу 193,080 нь хуулийн этгээдтэй байгуулсан даатгалын гэрээ байв.

ХУВЬ ХҮН **881,278**

ХУУЛИЙН ЭТГЭЭД **193,080**

САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧ — Орон нутаг

Даатгалын үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэгч өөр нэгэн үзүүлэлт нь даатгалын компанийн салбар, зуучлагчдын тоо юм. Орон нутагт даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлгээний нийт 1,763 төлөөлөгч, 440 салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байна.



БАРУУН БҮС	ХАНГАЙН БҮС	ТӨВИЙН БҮС	ЗҮҮН БҮС
ДААТГАГЧ 49	ДААТГАГЧ 57	ДААТГАГЧ 76	ДААТГАГЧ 28
ЗУУЧЛАГЧ 32	ЗУУЧЛАГЧ 46	ЗУУЧЛАГЧ 80	ЗУУЧЛАГЧ 25
ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ 5	ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ 14	ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ 21	ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ 7

ТӨЛӨӨЛӨГЧИД

492	566	479	226

САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧ — Улаанбаатар хот

- Улаанбаатар хотод нийт 297 салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулсан ба үүнээс даатгалын компанийн 48, даатгалын зуучлагчийн 208, хохирол үнэлэгчийн 41 салбар, төлөөлөгчийн газар байна. Эдгээрийг дүүргээр ангилан үзвэл салбар нэгжийн 92.3 хувь нь төвийн 6 дүүрэгт төвлөрчээ.
- Улаанбаатар хотод нийт 535 төлөөлөгч үйл ажиллагаа явуулсан байна.
- Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй даатгалын компанийн төлөөлөгчийн газар 12 байгаагаас БНХАУ–д нэг байна.

	СОНГИНО ХАЙРХАН	ЧИНГЭЛТЭЙ	СҮХБААТАР	БАЯНЗҮРХ
ДААТГАГЧ	4	9	11	5
ЗУУЧЛАГЧ	16	39	47	36
ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	9	4	8	9

	ХАН–УУЛ	БАЯНГОЛ	НАЛАЙХ	БАГАНУУР
ДААТГАГЧ	3	4	3	8
ЗУУЧЛАГЧ	32	28	6	4
ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	3	7	0	1

	БАГАХАНГАЙ
ДААТГАГЧ	1
ЗУУЧЛАГЧ	0
ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	0

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

23
Даатгалын хэлбэр

662
Давхардсан даатгалын бүтээгдэхүүний тоо



- Ердийн болон урт хугацааны даатгалын нийт 23 хэлбэрээс “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал”–аас бусад нь сайн дурын даатгалын хэлбэр юм.
- Давхардсан тоогоор даатгалын бүтээгдэхүүн 2021 оны 3 дугаар улиралтай харьцуулахад 41 бүтээгдэхүүнээр өсөж 662 болов. Энэ нь 2018 оны мөн улиралтай харьцуулахад 88 бүтээгдэхүүнээр нэмэгдсэн байгаа юм.
- Эдгээр 662 бүтээгдэхүүнийг даатгалын хэлбэрээр нь ангилан харахад 22.5 хувийг хөрөнгийн даатгал, 21.9 хувийг гэнэтийн осол, эмчилгээний даатгал, мөн 21.9 хувийг хариуцлагын даатгалын бүтээгдэхүүн тус тус эзэлж байгаа бол үлдсэн 33.7 хувийг бусад 20 даатгалын хэлбэр бүрдүүлж байна.

Ердийн даатгалын нийт хураамж

	2021.III	2022.III
Хөрөнгийн даатгал	29.5%	24.4%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	19.0%	22.3%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	15.3%	14.6%
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	12.0%	14.0%
Бусад ердийн даатгал	9.8%	10.3%
Хариуцлагын даатгал	9.0%	9.4%
Барилга угсралтын даатгал	1.6%	2.7%
Агаарын хөлгийн даатгал	3.1%	1.3%
Урт хугацааны даатгал	0.7%	1.0%

Ердийн даатгалын нөхөн төлбөр

	2021.III	2022.III
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	25.9%	33.7%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	28.5%	27.4%
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	19.0%	18.2%
Хөрөнгийн даатгал	11.8%	9.8%
Бусад ердийн даатгал	5.2%	7.9%
Урт хугацааны даатгал	3.5%	1.3%
Хариуцлагын даатгал	1.9%	1.0%
Барилга угсралтын даатгал	0.1%	0.7%
Санхүүгийн даатгал	4.1%	0.5%

АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нийт хураамж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.8 хувиар өсөж 32.2 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт даатгалын хураамжийн орлогын 14.9 хувийг эзэлж байна.
- Нөхөн төлбөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 98.3 хувийн өсөлттэй байна. Тайлант үед 23.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь салбарын нийт нөхөн төлбөрийн зардлын 33.7 хувийг бүрдүүлжээ.



ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИД

- Даатгалын зуучлагчдын төвлөрүүлсэн даатгалын болон давхар даатгалын хураамж 56.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин даатгалын зуучлагчдын зуучлалын шимтгэлийн орлого өмнөх оны мөн үед 9.7 тэрбум төгрөг байсан байснаас 16.5 хувиар өсөж 11.3 тэрбум төгрөгт хүрэв.



ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИД

- Даатгалын хохирол үнэлэгч компаниуд нийт 23,233 хохирлыг 35.3 тэрбум төгрөгөөр үнэлэв. Нийт даатгалын хохирол үнэлгээний орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 90.0 хувиар өсөж 1.9 тэрбум төгрөгт хүрлээ.



АШИГТ АЖИЛЛАГАА

ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ЦЭВЭР АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- Тайлант үед даатгалын компаниудын цэвэр ашиг 2021 оны 3 дугаар улиралтай харьцуулахад 33.8 хувиар, 2018 оны мөн үетэй харьцуулахад 2.1 хувиар буурч 14.1 тэрбум төгрөгт хүрсэн.
- Татварын дараах цэвэр ашгийн өсөлтийг бүлэглэн авч үзвэл цэвэр ашгийн хэмжээ буурсан 7, 50 хувь хүртэлх өсөлттэй 4, 50%–100%–ийн өсөлттэй 1, 100%–аас дээш өсөлттэй 5 даатгалын компани байна.



ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД

- Хохирол нөхөлтийн харьцаа 2021 оны 3 дугаар улиралтай харьцуулахад 7.0 пунктээр өссөн үзүүлэлттэй байв.
- Тайланд үед зардлын харьцаа 3.6 пунктээр буурч 59.9 хувь болжээ.
- Даатгалын салбарын цэвэр ахиуц ашгийн харьцаа 4.7 пунктээр буурч 6.4 хувьд хүрлээ.





АШИГТ АЖИЛЛАГААНЫ КОЭФФИЦИЕНТ

- Нийт хөрөнгийн өгөөж 1.7 пунктээр буурч 3.2 хувьд хүрсэн бол өөрийн хөрөнгийн өгөөж 3.8 пунктээр буурч 7.0 хувьд хүрэв.

- Даатгалын компаниуд нь 5.8 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлд, 2.0 тэрбум төгрөгийг хувь хүний орлогын албан татварт, 4.8 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварт төлж, нийт 12.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

- Монгол Улсын даатгалын зах зээлийн тулгамдаж буй асуудлын нэг нь валютын ханшийн эрсдэл юм.
- Даатгалын компаниудын дийлэнх нь гадаад улсад давхар даатгуулдаг бөгөөд сүүлийн гурван жилийн хугацаанд 1 жилд дунджаар 70.0 орчим тэрбум төгрөгийг гадаад улсруу шилжүүлсэн.
- Даатгалын компаниудын гадаад улсад төвлөрүүлсэн давхар даатгалын хураамжийн зардал даатгалын нийт хураамжийн 31.6 хувьтай тэнцэж байна.

31.6%
Давхар даатгалын хураамжийн нийт хураамжид эзлэх хувь

Давхар даатгалын хураамж



Тайлбар: Монголбанкны 2022.09.30–ны өдрийн ам,долларын хаалтын ханш.

- Даатгалын компаниуд нийт хөрөнгийн 57.9 хувь буюу 260.2 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтад байршуулснаас 69.6 хувь нь хадгаламж, хадгаламжийн сертификат, 30.2 хувь нь үнэт цаас, үлдсэн хувь нь хараат ба хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт хэлбэртэй байна.
- Хадгаламж, хадгаламжийн сертификат болон үнэт цаасны хөрөнгө оруулалтаас даатгалын компаниуд нийт 16.1 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон байна.

Хөрөнгө оруулалтын дүн
57.9%

Даатгалын нийт хөрөнгө оруулалт ба хадгаламжийн жигнэсэн дундаж хүү



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”–ийн хүрээнд зөвлөх сонгон шалгаруулж, “Даатгалын уламжлалт бус эрсдэл шилжүүлэх арга замуудыг хэрхэн бий болгох, хөрөнгийн зах зээл болон даатгалын зах зээлийг хэрхэн уялдуулах” чиглэлээр хамтран ажиллан, судалгаа хийж, санал зөвлөмж гаргахаар болов.
- Олон улсын даатгалын зохицуулагч байгууллагуудын холбоо (IAIS)–ны ORTF–ын ажлын хэсгийн гишүүнээр оролцож, «Даатгалын салбарын үйл ажиллагааны уян хатан байдалд тулгамдаж буй асуудлууд» баримт бичиг /Issues Paper on Insurance Sector Operational Resilience/–ийг хамтран боловсруулж байна.
- Хүртээмжтэй даатгалын асуудлаар Азийн орнуудын мэдлэг туршлага солилцох сүлжээ (MEFIN)–нээс 2022.07.05–ны өдөр “Ази дахь уур амьсгал, гамшгийн эрсдэлийн даатгал (CDRI)–ыг зохицуулах нь: Бодит байдал ба сонголтууд” сэдвийн хүрээнд холбогдох сургалтад хамрагдсан. Тус сургалтаар “Уур амьсгал, гамшгийн эрсдэлийн даатгалын хууль ёсны тодорхойлолт шаардлагатай юу? Бусад хүмүүсийн дунд уур амьсгал, гамшгийн эрсдэлийн даатгал нь хувийн эрсдэлийг агуулдаг уу? эсвэл зөвхөн амь насанд хамаарахгүй эрсдэлтэй холбоотой юу?”, “Засгийн газар хоорондын зохицуулалт, техникийн дэмжлэг ямар замаар илүү үр дүнтэй байх вэ?, “Хамтарсан даатгалын зохицуулалт нь зах зээлд суурилсан хандлагыг илүү үр дүнтэй болгоход тусалж чадах уу?” зэрэг сэдвийн хүрээнд мэдээлэл өгсөн.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Даатгалын багц хууль буюу Даатгалын тухай, Даатгалын зуучлалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл, ирүүлсэн саналууд, хуулийн төсөлд тусгагдсан асуудлуудын талаар холбогдох уулзалт, хэлэлцүүлгүүдийг Сангийн яам болон даатгалын мэргэжлийн холбоодыг хамруулан 2022 оны 8 болон 9 дүгээр саруудад зохион байгуулсан ба хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулан, УИХ–ын намрын чуулганд өргөн барихаар ажиллаж байна.
- Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2022.09.30–ны өдрийн 451/196 дугаар тушаалаар Жолоочийн даатгалын санд даатгагчаас төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоосон.

ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Санхүүгийн зохицуулах хорооноос “Эрсдэлд суурилсан төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”, “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”–ыг тус тус боловсруулан холбогдох хэлэлцүүлгийг 2022.09.27–ны өдөр даатгалын компаниудын удирдлага болон актуарчдыг хамруулан зохион байгуулсан.
- Даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг 7–9 дүгээр саруудад Сангийн яам, Монголын даатгалын холбоо, Монголын Даатгалын зуучлалын холбоо, Монголын Хөрөнгө, хохирол үнэлэгчдийн холбоо, Албан журмын даатгагчдын холбоо, Монголын банкны холбоо болон мэргэжлийн оролцогчдыг хамруулан зохион байгуулж хуулийн төсөлд ирүүлсэн саналууд, хэлэлцэх шаардлагатай асуудлуудын талаар санал солилцсон.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Нийт хөрөнгө

3.4

их наяд төгрөг

Санхүүгийн зах зээлийн төлөв

Хөрөнгийн өсөлт

38.2%

Харилцагч

4.9 сая

Хүртээмжтэй байдал

Дундаж зээлийн хэмжээ

1.6 сая төгрөг

Зээлийн ББСБ

92.7%

Бүтээгдэхүүн үйлчилгээ

Зөвхөн гадаад валютын арилжааны ББСБ

7.3%

Ашигт ажиллагаа
Нийт орлого
624.8
тэрбум төгрөг
Улсад татан төвлөрүүлсэн татвар, НДШ
49.5
тэрбум төгрөг
Тогтвортой байдал
Z индекс
26.9
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь
7.3%
Бодлого зохицуулалт

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

- Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 522 банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/ үйл ажиллагаа явуулав. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 14 ББСБ шинээр тусгай зөвшөөрөл авч, 26 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоод байна.



Нийт ББСБ-ын 26 буюу 5.0 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтаар, 496 буюу 95.0 хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай байна.

ББСБ-УУДЫН ХӨРӨНГӨ

ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 3.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 940.7 тэрбум төгрөгөөр буюу 38.2 хувиар, 2018 оны мөн үетэй харьцуулахад 2.3 их наяд төгрөгөөр буюу 2.8 дахин өсжээ.





ББСБ-уудын активын бүтэц /тэрбум төгрөгөөр/

Нийт хөрөнгийн дүн	**3,400.8**	**100.0%**
Эргэлтийн хөрөнгө	**3,294.2**	**96.9%**
Мөнгөн хөрөнгө	402.0	11.8%
Зээл /цэврээр/	2,524.0	74.2%
Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	16.0	0.5%
Факторингийн тооцооны авлага /цэврээр/	10.4	0.3%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	19.7	0.6%
Бусад хөрөнгө	322.1	9.5%
Эргэлтийн бус хөрөнгө	**106.6**	**3.1%**



ББСБ-уудын пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/

Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	**3,400.8**	**100.0%**
Өр төлбөр	**1,276.1**	**37.5%**
Санхүүгийн эх үүсвэр	354.0	10.4%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	407.2	12.0%
Бусад эх үүсвэр	53.7	1.5%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	200.2	5.9%
Төслийн зээлийн санхүүжилт	19.4	0.6%
Бусад өр төлбөр	241.6	7.1%
Эздийн өмч	**2,124.7**	**62.5%**
Хувьцаат капитал	1,275.5	37.5%
Бусад өмч	61.0	1.8%
Сангууд	2.7	0.1%
Хуримтлагдсан ашиг/ алдагдал	714.9	21.0%
Хоёрдогч өглөг	70.6	2.1%



Зах зээлд эзлэх хувь хэмжээ буюу нийт хөрөнгөд эзлэх хувиар нь харвал салбарын нийт хөрөнгийн:

- 25 хувийг хамгийн их хөрөнгө бүхий 5 ББСБ;
- 50 хувийг хамгийн их хөрөнгө бүхий 20 ББСБ;
- 75 хувийг хамгийн их хөрөнгө бүхий 107 ББСБ эзэлж байна.



	ББСБ-ын тоо		Нийт хөрөнгө		Нийт зээл		Зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь	Харилцагчдын тоо	
	Тоо	%	Хэмжээ /тэрбум төг/	%	Хэмжээ /тэрбум төг/	%		Тоо	%
Топ 25 %	5	1.0%	918.3	27.0%	771.8	28.9%	4.8%	232,972	4.8%
Топ 50 %	20	3.8%	1,704.9	50.1%	1,404.3	52.7%	5.2%	3,987,580	81.4%
Топ 75 %	107	20.5%	2,552.0	75.0%	2,072.2	77.7%	6.3%	4,760,076	97.2%
САЛБАРЫН НИЙТ	**522**	**100.0%**	**3,400.8**	**100.0%**	**2,666.1**	**100.0%**	**7.3%**	**4,897,575**	**100.0%**

Банк бус санхүүгийн зах зээлийн нийт хөрөнгийн 25, 50 болон 75 хувийг бүрдүүлж буй ББСБ-уудын зээлийн үлдэгдэл салбарын нийт зээлийн үлдэгдлийн 28.9, 52.7, болон 77.7 хувийг тус тус эзэлж байна. Нийт хөрөнгө болон нийт зээлийн үлдэгдлийн эзлэх хувь ойролцоо хэдий ч нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь харгалзан 4.8, 5.2 болон 6.3 хувьтай байна.

Салбарын нийт хөрөнгийн 50 хувийг бүрдүүлж буй 20 ББСБ-ууын зарим нь үйл ажиллагаандаа технологийн дэвшлийг ашиглан, хүртээмжтэй байдлаар үйлчилгээ үзүүлдэг тул нийт үйлчлүүлэгчдийн 81.4 хувь нь зөвхөн эдгээр ББСБ-уудын харилцагчид байна.

	ББСБ-ын тоо	Нийт хөрөнгө		Нийт зээл		Харилцагчдын тоо	
		Хэмжээ /тэрбум төг/	%	Хэмжээ /тэрбум төг/	%	Тоо	%
Дотоодын хөрөнгө оруулалт бүхий	496	2,883.2	84.8%	2,247.1	84.3%	4,761,157	97.2%
Гадаадын хөрөнгө оруулалт бүхий	26	517.6	15.2%	419.0	15.7%	136,418	2.8%

Нийт гадаад хөрөнгө оруулалт бүхий ББСБ-уудын 38.5 хувь буюу 10 нь Япон улсын, 26.9 хувь буюу 7 нь БНСУ-ын, 7.7 хувь буюу 2 нь АНУ-ын, АНУ, Япон улсын хамтарсан хөрөнгө оруулалттай 1, үлдсэн нь БНХАУ, ОХУ, Их Британи, Малайз, Хонг Конг, Канад зэрэг бусад улсын хөрөнгө оруулалттай байна. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьд салбарын нийт хөрөнгийн 15.2 хувийг эзэмшдэг бөгөөд нийт харилцагчдын 2.8 хувьд үйлчилгээ үзүүлдэг байна.



2022 оны 3 дугаар улирлын байдлаар ББСБ-уудын нийт хөрөнгө Монгол Улсын ДНБ-ий 7.9 хувьтай тэнцэхүйц хэмжээнд байна.

Нийт зээл /тэрбум төгрөг/



Зээлийн хүү: ББСБ-уудын олгосон зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 3.1 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр өссөн. Энэ нь 2018 оны мөн үетэй харьцуулахад 0.2 пунктээр буурсан үзүүлэлт юм.



НИЙТ ЗЭЭЛ

Салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 51.0 хувиар буюу 900.2 тэрбум төгрөгөөр, 2018 оны мөн үеэс 1.9 их наяд төгрөгөөр буюу 3.3 дахин өссөн дүнтэй байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 97.1 хувийг төгрөгөөр олгосон зээл, үлдсэн 2.9 хувийг валютаар олгосон зээл эзлэж байна.

97.1%

ХЭВИЙН

88.5%

+0.3%

ХУГАЦАА ХЭТЭРСЭН

4.2%

+1.3%

ЧАНАРГҮЙ

7.3%

-1.0%

2.4 их наяд төгрөг | Олгосон зээл

Төлөгдсөн зээл | 1.9 их наяд төгрөг

	Олгосон зээл	Төлөгдсөн зээл
Бөөний болон жижиглэн худалдаа	8.4%	8.2%
Барилга	4.0%	4.2%
Уул, уурхайн олборлолт	0.8%	1.0%
Машин, мотоциклийн засвар үйлчилгээ	2.8%	3.0%
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйлчилгээ	1.5%	1.4%
Боловсруулах үйлдвэр	0.9%	0.9%
Хөдөө аж, ахуй	0.6%	0.6%
Бусад	81.0%	80.7%

88.9%	ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ	11.1%
92.1%	ОЛГОСОН ЗЭЭЛ	7.9%
91.9%	ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ	8.1%

Нийт зээлийн үлдэгдлийн 88.9 хувь нь иргэнд олгосон зээл, 11.1 хувь нь хуулийн этгээдэд олгосон зээл байна.



ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ

Нийт олгосон зээлийн 71.4 хувь, төлөгдсөн зээлийн 72.2 хувийг хэрэглээний зориулалттай зээл бүрдүүлж байна.



ББСБ-ын салбарын олгосон зээлийн хамгийн ихээс нь эрэмбэлбэл 24.5 хувийг 1–2.5 жилийн хугацаатай, 21.2 хувийг 1 сар хүртэлх хугацаатай, 18.6 хувийг 6–12 сарын хугацаатай зээл тус тус байгаа ба нийт олгосон зээлийн 64.3 хувийг бүрдүүлж байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Улсын хэмжээнд тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхэлж буй 522 ББСБ нийт 419 салбартай. ББСБ–ын байршлыг зураглалаар харуулбал дийлэнх нь буюу 82.6 хувь буюу 431 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.



БАРУУН БҮС	ХАНГАЙН БҮС	ТӨВИЙН БҮС	ЗҮҮН БҮС
12 ББСБ	30 ББСБ	36 ББСБ	13 ББСБ
22 САЛБАР	50 САЛБАР	57 САЛБАР	27 САЛБАР

100,000 ХҮНД НОГДОХ ББСБ



1,000 АЖ АХУЙН НЭГЖИД НОГДОХ ББСБ



AFI–с санхүүгийн хүртээмжийг тооцоход сонголттой байдлын үзүүлэлт болох дор хаяж 3 санхүүгийн байгууллага бүхий засаг захиргааны нэгжийн хувийг тооцохыг зөвлөсөн байдаг. Нийт 21 аймгийн 57.1 хувь буюу 12 аймагт 3 буюу түүнээс дээш тооны ББСБ байна.



Улаанбаатар хотод үйлажиллагаа эрхэлж буй 431 ББСБ–ын 33.9 хувь нь Сүхбаатар дүүрэгт, 27.1 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 16.9 хувь нь Баянгол дүүрэгт, 11.1 хувь нь Баянзүрх дүүрэгт, 8.7 хувь нь Хан–Уул дүүрэгт, 2.1 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 0.2 хувь нь Багануур дүүрэгт тус тус байршилтай байна.

ББСБ–УУДЫН ХҮРТЭЭМЖ, ГАЗАРЗҮЙН БАЙРШЛААР

- Монгол Улсын хэмжээнд 18–64 насны 100,000 иргэнд 48 ББСБ, 1000 аж ахуйн нэгжид 32 ББСБ ногдож байна.
- Орон нутгийн хэмжээнд уг харьцаанууд нь 24, 8 байгаа бөгөөд бүс нутгийн хувьд төвийн бүс 100,000 иргэнд 30, зүүн бүс 1000 аж ахуй нэгжид 11 ББСБ ногдож байгаагаар ББСБ–ын хүртээмжээр тэргүүлж байна.
- Улаанбаатар хотын хувьд 100,000 иргэнд 77, 1000 аж ахуйн нэгжид 10 ББСБ ногдож байгаа нь хөдөө орон нутгаас хүртээмж сайтай байна



ДУНДАЖ ЗЭЭЛ

- Монгол Улсын хэмжээнд ББСБ–аас нэг зээлдэгч дунджаар 1,621.3 мянган төгрөгийн зээл авсан бол орон нутагт энэхүү үзүүлэлт 3,065.2 мянган төгрөг, Улаанбаатар хотын хувьд 1,605.6 мянган төгрөг байна.
- Харин уг үзүүлэлт өмнөх оны мөн үед улсын хэмжээнд 1,130.0 мянган төгрөг байсан ба тайлант улирлын хувьд ББСБ–ын нэг зээлдэгчид ногдох зээлийн дундаж хэмжээ 491.3 мянган төгрөгөөр буюу 43.5 хувиар өсжээ.
- Энэхүү үзүүлэлтээр өмнөх оны мөн үеэс зээлдэгчийн тоо болон зээлийн хэмжээ өссөн харагдаж байна.
- Нийт зээлдэгчдийн тоо 1.6 сая байгаа нь давхардсан тоогоор хөдөлмөрийн насны буюу 18–64 насны 100 хүн тутмын 84 нь банк ББСБ–аас зээлтэй байна гэсэн үг юм.

ББСБ–ын харилцагчид



ББСБ–ын зээлдэгчид /насны бүлгээр/



ББСБ–ын зээлдэгчид /боловсролын түвшингээр/



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ББСБ-ЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/



БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО

- ББСБ–уудын нийт орлого 624.8 тэрбум төгрөгт хүрэв.
- Нийт орлогын 97.7 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу хүүгийн болон хүүгийн бус орлого бүрдүүлж байна. Үүнээс нийт орлогын 80.1 хувь буюу 500.6 тэрбум төгрөгийг хүүгийн орлого, 17.6 хувь нь буюу 110.0 тэрбум төгрөгийг хүүгийн бус орлого бүрдүүлж байна



ХҮҮГИЙН БУС ОРЛОГЫН ЗАДАРГАА

- Хүүгийн бус орлогын 42.45 хувийг үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого, 22.4 хувийг ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого, 21.03 хувийг арилжааны орлого, 1.73 хувийг мөнгөн гуйвуулгын орлого, 0.05 хувийг итгэлцлийн үйлчилгээний орлого, 0.04 хувийг санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого, 12.3 хувийг бусад орлого тус тус бүрдүүлж байна.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ

- Нийт зардал 389.8 тэрбум төгрөгт хүрсэн ба 77.9 хувийг үндсэн үйл ажиллагааны зардал буюу хүүгийн болон хүүгийн бус зардал бүрдүүлж байна. Үүнээс нийт зардлын 60.3 хувь буюу 234.9 тэрбум төгрөгийг хүүгийн бус зардал, 17.6 хувь нь буюу 68.6 тэрбум төгрөгийг хүүгийн зардал бүрдүүлж байна.
- Бусад зардлын хувьд үндсэн бус үйл ажиллагааны зардал 4.9 тэрбум, болзошгүй эрсдэлийн зардал 51.9 тэрбум, орлогын албан татварын зардал 29.4 сая төгрөг байна.



Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэлтэй холбоотой гарах зардал буюу болзошгүй эрсдэлийн зардлын хувьд нийт 51.9 тэрбум төгрөг ба үүний 89.3 хувийг зээлийн эрсдэлийн зардал, 9.0 хувийг өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн зардал, 1.7 хувийг авлагын эрсдэлийн зардал бүрдүүлж байна.

- Факторингийн үйлчилгээ гэдэг нь зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүхэлд нь хариуцах үйл ажиллагааг хэлдэг. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар салбарын хэмжээнд нийт 10.4 тэрбум төгрөгийн факторингийн цэвэр авлага бүртгэлтэй байна.

Факторингийн үйлчилгээний цэвэр авлага /тэрбум төгрөг/



- Салбарын хэмжээнд нийт 61 ББСБ итгэлцлийн үйлчилгээг эрхэлж байна.
- Тэдгээрийн үзүүлсэн итгэлцлийн үйлчилгээний нийт өглөг 354.0 тэрбум төгрөг байгаа ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63.5 хувиар өслөө.

Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөг/



Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний орлого /тэрбум төгрөг/



- 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 37 ББСБ мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл эзэмшиж байгаагаас 10 нь 1.9 тэрбум төгрөгийн орлогыг олжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 335.5 сая төгрөгөөр буюу 15.0 хувиар буурсан үзүүлэлт юм.

ХУДАЛДСАН, ХУДАЛДАН АВСАН ВАЛЮТЫН МЭДЭЭ

ББСБ-ууд нийт 3,692.0 тэрбум төгрөгийн валют худалдан авч, 3,912.5 тэрбум төгрөгийн валютыг худалдсан байна. Худалдаж авсан валютын 44.8 хувийг, худалдсан валютын 45.0 хувийг БНХАУ-ын юань бүрдүүлж байна.

ВАЛЮТЫН НЭР	Худалдаж авсан Дүн /тэрбум төгрөг/	Худалдсан Дүн /тэрбум төгрөг/
БНХАУ-ЫН ЮАНЬ	1,653.0	1,763.0
АНУ-ЫН ДОЛЛАР	1,521.0	1,547.0
ЕВРО	253.0	297.6
ЯПОНЫ ИЕН	132.2	134.0
ОХУ-ЫН РУБЛЬ	94.3	130.6
БНСУ-ЫН ВОН	31.4	32.6
БУСАД	7.1	7.7

Тайлбар: 2022 оны 3 дугаар улирлын валют арилжааны хэмжээнд өмнөх улирлын алдааг залруулсан болно.

ФИНТЕК

36 ББСБ

5 Зөвхөн технологид суурилсан

31 Технологи + Уламжлалт

- Салбарын нийт харилцагчдын 92.2 хувь, зээлдэгчдийн 88.8 хувь нь эдгээр банк ББСБ–ын харилцагчид буюу технологид суурилсан зээлийн үйлчилгээг хүртэх боломжтой байна.
- Нийт зээлдэгчдийн 43.3 хувь нь зөвхөн гар утсаараа дамжуулан зээл авч байна.

- Санхүүгийн үйлчилгээнд технологийн дэвшил ашиглаж буй ББСБ–уудын зээлийн үлдэгдлийн 89.3 хувийг хэвийн зээл, 4.4 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 6.3 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүллээ.

89.3% Хэвийн

4.4% Хугацаа хэтэрсэн зээл

6.3% Чанаргүй



Финтекийн зээлдэгчид нийт зээлдэгчдийн 88.8 хувийг зээлж байгаа хэдий ч тэдгээрийн зээлсэн дундаж зээлийн хэмжээ уламжлалт зээлээс даруй 53.1 дахин бага байна.

	Нийт зээл		Зээлдэгчийн тоо		1 зээлдэгчид ногдох дундаж зээлийн хэмжээ /мян. төгрөг/
	Хэмжээ /тэрбум төг/	%	Тоо	%	
Финтек	346.8	13.0%	1,460,376	88.8%	237.5
Уламжлалт	2,319.3	87.0%	184,047	11.2%	12,601.8
НИЙТ	**2,666.1**	**100.0%**	**1,644,423**	**100.0%**	**1,621.3**

АШИГТ АЖИЛЛАГАА



ROE болон ROA–ийн харгалзах интервал дахь ББСБ–ын тоо /хувиар/

(*) Жишээ нь: Нийт ББСБ–уудын 25.3 хувь нь 1 хувиас доош өөрийн хөрөнгийн өгөөжтэй ажиллаж байна



НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖИЙН ХАРЬЦАА /ХӨРӨНГИЙН АНГИЛЛААР/

ББСБ–уудын нийт болон өөрийн хөрөнгийн өгөөжийг хувь нийлүүлсэн хөрөнгийн ангиллаар харахад 1.0 тэрбум төгрөгөөс доош хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ–уудын тал хувь нь 4.4 хувиас бага, 1–2.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ–уудын тал хувь нь 5.0 хувиас бага, 2.5 тэрбум төгрөгөөс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ–уудын тал хувь нь 9.1 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй байна. Өөрийн хөрөнгийн өгөөжийн хувьд холбогдох утгууд нь харгалзан 4.9, 5.3 болон 11.9 хувьтай байна.

ЗАРДАЛ, ОРЛОГЫН ХАРЬЦАА

Зардал, орлогын харьцаа: ББСБ–ууд нэг төгрөгийн орлого олохын тулд дунджаар хэдэн төгрөгийн зардал гаргаж буйг тооцдог харьцаа болох зардал, орлогын харьцаа тайлант улиралд 48.6 хувь гарсан буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.6 пунктээр өсжээ. Өөрөөр хэлбэл ББСБ–ууд 100 төгрөгийн орлого олохын тулд дунджаар 48.6 төгрөгийн зардал гаргаж байна гэсэн үг юм.

- Нийт ББСБ–ууд нь 2022 оны 3 дугаар улиралд НДШ–д 14.9 тэрбум төгрөг, ХХОАТ–т 5.2 тэрбум төгрөг, ААН–ийн орлогын албан татварт 29.4 тэрбум төгрөгийг тус тус төлж, нийт улсын төсөвт 49.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд байна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

o AFI –с санхүүгийн хүртээмж болон санхүүгийн тогтвортой байдлыг тодорхойлох зөвлөмж зааврын дагуу ББСБ–уудын дараах 4 үзүүлэлтийг тооцож байна. Үүнд:



ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХАРЬЦАА

o Тайлант улиралд уг харьцаа 106.0 хувь гарч байгуулбал зохих эрсдэлийн санг бүрдүүлж чадсан бөгөөд эрсдэлийг 106.0 хувиар нөхөх чадамжтайг харуулжээ.

o Энэ нь өмнөх оны мөн үеэс 4.2 пунктээр өссөн үзүүлэлт юм.

106.0%

Тэрбум төгрөг



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ

Чанаргүй зээлийн хэмжээ 194.7 тэрбум төгрөгт хүрч чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 7.3 хувь болж буурлаа. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.0 пунктээр буурсан байна.



ХӨРВӨХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА

- Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа буюу хөрвөх чадвар тайлант улиралд 11.8 хувь болжээ.
- Мөнгөн хөрөнгө 7.8 хувиар буурч, нийт хөрөнгө 38.2 хувиар өссөн бөгөөд хөрвөх чадвар 5.9 пунктээр буурсан байна.



Z ИНДЕКС

Z индекс нь ББСБ–ын дампуурах магадлалыг харуулдаг ба нийт хөрөнгийн өгөөж болон өөрийн хөрөнгийн харьцааны нийлбэрийг нийт хөрөнгийн өгөөжийн хэлбэлзэлд харьцуулж тооцдог. Z индексийн утга ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хөшүүрэг өндөр байх үед их гарах ба өгөөжийн хэлбэлзэл ихтэй үед буюу орлогын тодорхойгүй байдал их үед бага гарна. Өөрөөр хэлбэл индексийн их утга нь эрсдэл багатай, тогтвортой байдлыг илэрхийлдэг. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын Z индекс өмнөх оны мөн үеэс 0.7 пунктээр өсөж 26.9 боллоо.

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Санхүүгийн зохицуулах хороо нь банк бус санхүүгийн байгууллагын салбарын бодлого зохицуулалтын чиглэлээр дараах олон улсын байгууллага, холбоодтой хамтран ажиллаж байна.

- ToC Холбоо ББСБ–уудын Тогтвортой санхүүгийн тогтолцооны талаарх одоогийн ойлголт, мэдээллийг үнэлэх, тэдгээрийн зээл олгох үйл ажиллагаанд учирч болзошгүй Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн хүчин зүйлүүдийг тодорхойлох судалгааг эхлүүлэн судалгааны үр дүнд Санхүүгийн байгууллагуудад зориулсан жишиг байгаль орчин, нийгэм, засаглалын удирдлага (БОНЗУ)–ын журмын төслийг боловсруулаа. Түүнчлэн Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төслийн хүрээнд ББСБ–ын үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд чиглэсэн Байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээний тогтолцоог боловсруулаад байна.
- Азийн хөгжлийн банк (АХБ)–тай хамтран 2022 оны 8 дугаар сараас эхлэн хэрэгжүүлэх Финтекийн хууль эрх зүй, зохицуулалтын орчныг хөгжүүлэх (Developing Fintech Legal and Regulatory Frameworks for Mongolia) төслийн баримт бичиг, АХБ, СЗХ–той байгуулах санамж бичгийн төслийг эцэслэх уулзалтыг 2022 оны 8 дугаар сарын 04–ний өдөр цахимаар зохион байгууллаа.
- AFI болон Йорданы Төв банктай хамтран зохион байгуулж буй Дэлхийн бодлогын форумд Монгол Улсыг төлөөлж оролцлоо. “Уян хатан, хүртээмжтэй, тогтвортой ирээдүй рүү хамтдаа” сэдвийн дор Йорданы Хашимитын Вант Улсад 9 дүгээр сарын 5–8–ны өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд энэ удаагийн форумд дэлхийн 80 гаруй орны 500 гаруй санхүүгийн зохицуулагч байгууллага, төв банкны төлөөлөл болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөгчид оролцож “Ковид–19” ба дэлхийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдал, цар тахлын дараах санхүүгийн үйлчилгээг илүү хүртээмжтэй, нээлттэй болгоход чиглэсэн бодлого, шийдлийн талаар хэлэлцлээ.
- “Хүртээмжтэй ногоон санхүүжилт” ажлын хэсгийн хурлаар СЗХ–г төлөөлж санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, түүний шийдэл, сайн туршлагын талаар байр сууриа илэрхийлсэн бөгөөд тус хурлаар Ногоон санхүүгийн замын зураг болон Байгаль орчин, нийгэм засаглалын эрсдэлийн удирдлагын бодлого боловсруулах ажлын хэсгүүдийг байгуулж, СЗХ–ны төлөөлөл нь Ногоон санхүүгийн замын зургийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байна.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ–д өргөн мэдүүлж, салбарт мөрдөгдөх дүрэм, журмуудыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн батлахын зэрэгцээ бодлого, зохицуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ:

- “Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, Санхүүгийн тайлангийн маягт, Дансны нэгдсэн жагсаалт, Санхүүгийн тайлангийн тодруулгын төслийг батлуулахаар Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 3 дугаар сарын 09–ний өдрийн №7/897 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 4 дүгээр сарын 06–ны өдрийн 160 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт заасан Финтек зээлийн үйлчилгээ эрхэлж буй ББСБ–уудыг бүртгэх хугацааг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 6 дугаар сарын 22–ны өдрийн 362 дугаар тогтоолоор 2022 оны 12 дугаар сарын 31–ний өдрийг хүртэлх хугацаанд сунгасан.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”–ын 5.2 дахь хэсгийг үндэслэн Цахим зөвлөлийн дүрмийг 2022 оны 09 дүгээр сарын 27–ны өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны даргын 434 дүгээр тушаалаар батлав.

“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2022 оны 3 дугаар улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4–т заасны дагуу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 88.8% буюу 451 ББСБ, нийтэд мэдээллэх үүргийг 83.1% буюу 422 ББСБ хэрэгжүүлсэн байна.

“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээг байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүрэгтэй. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 3 дугаар сарын 03–ны өдрийн А–57 дугаар тушаалаар “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”–ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг нэгдсэн журмаар шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж, энэхүү ажлын хүрээнд тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 489 ББСБ–ын 86.7% буюу 424 ББСБ гэрээгээ шинэчлэн байгуулсан байна.

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1–д “Энэ хуулийн 4.1–д заасан этгээд 20.0 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй” гэж заасны дагуу нэр бүхий 115 ББСБ, 9,138 удаагийн тохиолдлоор, 1.5 их наяд төгрөгийг, 7.2–т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1–д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ” гэж заасны дагуу нэр бүхий 8 ББСБ, 34 удаагийн тохиолдлоор, 1.6 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА–нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Нийт хөрөнгө

266.7 тэрбум төгрөг

Хөрөнгийн өсөлт **–7.8%**

Санхүүгийн зах зээлийн төлөв

Нийт салбар **63**

Нийт гишүүдийн тоо

72,770

Хүртээмжтэй байдал

Хэрэглээ болон түүнтэй холбогдох бусад зориулалтаар олгогдсон зээл

22.4%

Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа

Цэвэр ашиг

7.5

тэрбум төгрөг

Улсад татан төвлөрүүлсэн татвар, НДШ

2.7

тэрбум төгрөг

Тогтвортой байдал

Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь

3.6%

Бодлого зохицуулалт

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

ХЗХ-ДЫН ТОО БА ГИШҮҮД

- 2022 оны 3 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23-оор буюу 10.2 хувиар буурч 202 хүрсэн.
- ХЗХ-дын гишүүдийн тоо 2021 оны 3 дугаар улиралд 75,771 байсан бол тайлант үед 4.0 хувиар буурч 72,770 гишүүнтэй болжээ.
- ХЗХ-дын тоо 2018 оны 3 дугаар улиралд 288 байсан бол тайлант улиралд 29.9 хувиар буурсан. Харин ХЗХ-дын гишүүдийн тоо 2018 оны 3 дугаар улиралд 61,881 байсан бол 2022 оны 3 дугаар улиралд 17.6 хувиар өсжээ.



АЖИЛЛАГСАД

703

ХЗХ-дын нийт ажилтнуудын тоо 703 хүрч өнгөрсөн оны мөн үеэс 8.5 хувиар буурсан бөгөөд түүний 69.4 хувь нь эмэгтэй ажиллагсад байна.

НИЙТ ГИШҮҮДИЙН

38,212 ЗӨЗЛДӨГЧ

37,666 ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧ



НИЙТ ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ ӨСӨЛТ

- Тайлант улиралд нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар буурч 266.7 тэрбум төгрөгт хүрлээ.
- Хөрөнгийн өсөлтийн инерци өмнөх оны мөн үеэс 31.4 пунктээр буурсан.
- Тайлант үеийг 2018 оны 3 дугаар улиралтай харьцуулахад ХЗХ-ны нийт хөрөнгийн дүн 74.4 тэрбум төгрөгөөр буюу 38.7 хувиар нэмэгдэж 266.7 тэрбум төгрөгт хүрсэн.

НИЙТ ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

- 87.2 хувийг 1 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 30 ХЗХ;
- 5.0 хувийг 500 саяас 1 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй 19 ХЗХ;
- 7.8 хувийг 500 сая төгрөгөөс доош хөрөнгөтэй 153 ХЗХ эзэлж байна.

ХЗХ–дын актив болон пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/

Нийт хөрөнгийн дүн	**266.7**	**100.0%**
Эргэлтийн хөрөнгө	**262.5**	**98.4%**
Мөнгөн хөрөнгө	30.5	11.4%
Зээл /цэврээр/	210.4	78.9%
Авлага	19.3	7.2%
Бусад эргэлтийн хөрөнгө	1.3	0.5%
Өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	0.8	0.3%
Эргэлтийн бус хөрөнгө	**4.1**	**1.6%**
Үндсэн хөрөнгө /цэврээр/	4.0	1.5%
Биет бус хөрөнгө /цэврээр/	0.2	0.1%
Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.01%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	**266.7**	**100.0%**
Өр төлбөр	**210.6**	**79.0%**
Хадгаламж	189.8	71.1%
Богино хугацаат зээл	2.6	1.0%
Бусад богино хугацаат өр төлбөр	14.6	5.5%
Урт хугацаат өр төлбөр	3.7	1.4%
Өөрийн хөрөнгө	**56.1**	**21.0%**
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	26.1	9.7%
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.2	0.1%
Хоршоологчдын өмч	29.9	11.2%



- Нийт хөрөнгийн 98.4 хувь нь эргэлтийн хөрөнгө, үлдсэн 1.6 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байна.
- Нийт хөрөнгийн 11.4 хувийг мөнгөн хөрөнгө, 78.9 хувийг зээлийн цэвэр үлдэгдэл, 7.2 хувийг авлагын үлдэгдэл бүрдүүлж байна.
- Эх үүсвэрийн хувьд нийт хөрөнгийн 79.0 хувийг өр төлбөр, 21.0 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ



БАРУУН БҮС
42 ХЗХ
8 САЛБАР

ХАНГАЙН БҮС
20 ХЗХ
17 САЛБАР

ТӨВИЙН БҮС
21 ХЗХ
20 САЛБАР

ЗҮҮН БҮС
9 ХЗХ
11 САЛБАР

УЛААНБААТАР
110 ХЗХ
7 САЛБАР

- Тайлант улиралд нийт 202 ХЗХ-ноос 110 ХЗХ нь Улаанбаатар хотод, 92 ХЗХ нь хөдөө, орон нутагт бүртгэлтэй байна.
- Хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын 45.7 хувь нь баруун бүсэд, 9.8 хувь нь зүүн бүсэд, 21.7 хувь нь хангайн бүсэд, 22.8 хувь нь төвийн бүсэд байршжээ.
- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 110 ХЗХ-ны 95.5 хувь нь төвийн зургаан дүүрэгт, 4.5 хувь нь алслагдмал гурван дүүрэгт байршиж байна.



ЧИНГЭЛТЭЙ	20
СҮХБААТАР	27
БАЯНГОЛ	11
СОНГИНО ХАЙРХАН	17
БАЯНЗҮРХ	17
ХАН–УУЛ	13
НАЛАЙХ	3
БАГАНУУР	2
БАГАХАНГАЙ	0

AFI–н санхүүгийн хүртээмжийн тоон мэдээллийн ажлын хэсгээс улс орнуудын санхүүгийн хүртээмжийг үнэлэх үндсэн индикаторуудыг[1] 2013 онд гаргасан. Тус индикаторуудыг ашиглан салбарын хүртээмжтэй байдлыг харуулъя. Үүнийг хөдөлмөрийн насны буюу 18–64 насны 10,000 хүнд ногдох, 1,000 аж ахуйн нэгж (ААН)–д ногдох ХЗХ–дын тоогоор илэрхийлж болно.



- 1,000 ААН–д ногдох ХЗХ–ны тоогоор Налайх дүүрэг 7.9, Багануур 4.0 үзүүлэлттэйгээр тус тус тэргүүлж байгаа бол Баянгол дүүрэг 0.9 гэсэн үзүүлэлттэйгээр хамгийн доогуур жагсаж байна.
- Харин 10,000 хүнд ногдох ХЗХ–ны тоогоор Сүхбаатар, Налайх, Чингэлтэй дүүргүүд тус тус 3.2, 2.7, 2.3 гэсэн үзүүлэлтээр тэргүүлж байна.

[1] *https://www.afi–global.org/sites/default/files/publications/fidwg–core–set–measuring–fi.pdf*

Хүртээмжийн үзүүлэлтийг 4 бүсээр ангилахад баруун бүс 10,000 хүнд ногдох, 1,000 ААН–д ногдох ХЗХ–дын тоогоор бусад бүсээс сайн үзүүлэлттэй байна.

Нэг гишүүнд ногдож буй дундаж зээл



ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18–аас 64 насны 50 хүн тутмын нэг нь ХЗХ–нд гишүүнчлэлтэй, зээлийн үйлчилгээг хүртэж байна.
- Дээрх үзүүлэлт нь хөдөө, орон нутагт 65 хүн тутмын нэг байгаа бол Улаанбаатар хотын хэмжээнд 40 хүнд нэг тохиож байна.
- Улсын хэмжээнд ХЗХ–ноос зээл авсан нэг зээлдэгч гишүүн дунджаар 5.7 сая төгрөгийн зээлтэй байна.
- Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 7.6 сая төгрөг байгаа бол хөдөө, орон нутагт 3.0 сая төгрөг байна.

ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18–аас 64 насны 51 хүн тутмын нэг нь ХЗХ–нд хадгаламжийн үйлчилгээг хүртэж байна.
- Дээрх үзүүлэлт хөдөө, орон нутагт 56 хүнд нэг байгаа бол Улаанбаатар хотын хэмжээнд 46 хүнд нэг тохиож байна.
- Улсын хэмжээнд ХЗХ–нд хадгаламжтай нэг хадгаламж ээмшигч гишүүн дунджаар 5.0 сая төгрөгийн хадгаламжтай байна.
- Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 7.9 сая төгрөг байгаа бол хөдөө, орон нутагт 2.1 сая төгрөг байна.

Нэг гишүүнд ногдож буй хадгаламжийн дундаж хэмжээ

ХЗХ-НЫ ГИШҮҮДИЙН ХҮРТЭЭМЖ



НАСНЫ БҮЛГЭЭР



БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР



Нийт ажилчдын тоо **703**

Үүнээс эмэгтэй 488

Нийт зээлдэгчдийн тоо **32,212**

эмэгтэй 18,153

хуулийн этгээд 96

Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо **37,666**

Эмэгтэй 20,751

Хуулийн этгээд 66

Нийт гишүүдийн тоо **72,770**

Эрэгтэй 32,241

Эмэгтэй 39,314

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ХЗХ-ДЫН ЗЭЭЛ

- Тайлант үед нийт зээлийн хэмжээ 216.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар өслөө.
- Цэвэр зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс мөн адил 3.9 хувиар өсөж 210.4 тэрбум төгрөгт, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 1.8 хувиар өсөж 5.7 тэрбум төгрөгт хүрлээ.
- Тайлант үеийг 2018 оны 3 дугаар улиралтай харьцуулахад ХЗХ-ны нийт зээлийн үлдэгдлийн дүн 73.9 тэрбум төгрөгөөр буюу 52.0 хувиар нэмэгдэж 216.1 тэрбум төгрөгт хүрсэн.



ХЭВИЙН

94.0%

ХУГАЦАА ХЭТЭРСЭН

2.4%

ЧАНАРГҮЙ

3.6%

ХЗХ-ДЫН ЗЭЭЛИЙН ЧАНАР

- Тайлант үед хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар өсөж 203.0 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт зээлийн 94.0 хувийг хэвийн зээл эзэлж байна.
- Хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар буурч 5.2 тэрбум төгрөгт хүрлээ.
- Чанаргүй зээлийн хэмжээ 2.5 хувиар буурч 7.8 тэрбум төгрөгт хүрлээ.
- Тайлант үеийг 2018 оны 3 дугаар улиралтай харьцуулахад ХЗХ-ны салбарын нийт чанаргүй зээлийн дүн 1.6 тэрбум төгрөгөөр буюу 26.1 хувиар нэмэгдэж 7.8 тэрбум төгрөгт хүрсэн.

ХЗХ-ДЫН ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

- Нийт олгосон зээлийн 61.6 хувь нь хэрэглээ болон түүнд холбогдох бусад зориулалтаар, 13.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 6.5 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, үлдсэн 18.8 хувь нь бусад зориулалтаар тус тус олгогдсон байна.
- Нийт эргэн төлөгдсөн зээлийн 67.2 хувь нь хэрэглээ болон түүнд холбогдох бусад зориулалтаар олгосон зээлээс, 12.2 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдааны үйл ажиллагаанаас, 5.5 хувь нь хөдөө аж ахуйн салбараас, үлсдэн 15.1 хувь нь бусад салбараас тус тус эргэн төлөгдсөн байна.

	ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ	ОЛГОСОН ЗЭЭЛ
Хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл	22.7%	22.4%
Бөөний, жижиглэн худалдаа	11.3%	12.2%
Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	0.6%	0.6%
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	5.0%	6.1%
Санхүүгийн, даатгалын үйл ажиллагаа	4.0%	5.0%
Барилга	3.6%	4.3%
Машин мотоциклийн засвар үйлчилгээ	1.4%	1.8%
Боловсруулах үйлдвэр	1.0%	0.8%
Байр орон сууц, хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	1.8%	2.3%
Бусад	48.6%	44.5%



НИЙТ ХАДГАЛАМЖ

- 98.6 хувийг хугацаатай хадгаламж, 1.4 хувийг хугацаагүй хадгаламж бүрдүүлж байна.

ХЗХ-ДЫН ХАДГАЛАМЖ

- ХЗХ-дын нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар буурч 189.8 тэрбум төгрөг боллоо.
- Тайлант улирлыг 2018 оны 3 дугаар улиралтай харьцуулахад ХЗХ-ны нийт хадгаламжийн хэмжээ 55.3 тэрбум төгрөгөөр буюу 41.1 хувиар нэмэгдэж 189.8 тэрбум төгрөгт хүрсэн.

98.6%

ХУГАЦААТАЙ

1.4%

ХУГАЦААГҮЙ

195 ХЗХ

7 ХЗХ

- Тайлант улиралд ХЗХ-дын 96.5 хувь буюу 195 ХЗХ нь нийт 189.8 тэрбум төгрөгийн хадгаламж төвлөрүүлсэн.
- Үлдсэн 3.5 хувь буюу 7 ХЗХ хадгаламж татаагүй байна.



НИЙТ ХАДГАЛАМЖИД ЭЗЛЭХ ХУВЬ

- 1 тэрбумаас дээш төгрөгийн хадгаламжтай 21 ХЗХ нь нийт 165.9 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 87.4 хувийг;
- 10 саяас 1 тэрбум төгрөгийн хадгаламжтай 150 ХЗХ нь нийт 23.8 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 12.5 хувийг;
- 10 саяас доош төгрөгийн хадгаламжтай 31 ХЗХ нь нийт 0.1 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 0.1 хувийг тус тус бүрдүүлж байна.
- 7 ХЗХ нь хадгаламж татаагүй.

1.2%

Хадгаламжийн жигнэсэн дундаж сарын хүү

2.4%

Зээлийн жигнэсэн дундаж сарын хүү

	2021.I	2021.II	2021.III	2021.IV	2022.I	2022.II	2022.III
ЗЖДХ	2.4	2.5	2.2	2.2	2.1	2.12	2.4
ХЖДХ	1.4	1.4	1.4	1.2	1.1	1.22	1.2

БУСАД ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ ХЗХ	2021.III	2022.III
Төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй	70	59
Санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй	4	5
Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй	5	5
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	1	1
Салбарын зөвшөөрөлтэй	САЛБАР–64	САЛБАР–63

ОРЛОГО

- ХЗХ–дын нийт хүүгийн орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6.7 хувиар өсөж 41.7 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт хүүгийн орлогын 94.5 хувийг зээлийн хүүгийн орлого эзэлж байна.
- Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого 5.0 хувийг, зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого 0.5 хувийг тус тус эзэлжээ.

ЗАРДАЛ

- ХЗХ–дын нийт хүүгийн зардал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өсөлт үзүүлээгүй ба 23.7 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт хүүгийн зардлын 96.8 хувийг хадгаламжийн хүүгийн зардал эзэлж байна.
- Хүүгийн зардлын 3.1 хувийг зээлж буй банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүү өмнөх оны мөн үеэс 143.1 хувиар өсөж 732.7 сая төгрөг болжээ.
- Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал 297,800 төгрөг гарсан байна.

АШИГТ АЖИЛЛАГАА

ХЗХ-ДЫН ОРЛОГО, ЗАРДАЛ

- Тайлант үед нийт ХЗХ 44.0 тэрбум төгрөгийн орлого, 36.5 тэрбум төгрөгийн зардал, 7.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан.
- Цэвэр ашгийн нийт орлогод эзлэх хувь өмнөх оноос өөрчлөлт үзүүлээгүй ба 17.1 хувь байна.





НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ

- ХЗХ-дын өөрийн хөрөнгийн өгөөж нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 пунктээр буурч 14.6 хувьд хүрлээ.
- Нийт хөрөнгийн өгөөж нь 0.1 пунктээр буурч 3.0 хувьд хүрчээ.

- ХЗХ-д тайлант улиралд НДШ-д 1.4 тэрбум төгрөг, ХХОАТ-т 0.5 тэрбум төгрөг, ААН-ийн орлогын албан татварт 0.8 тэрбум төгрөгийг тус тус төлж, нийт улсын төсөвт 2.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд байна.

ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД

- Тайлант үед хүүгийн орлогын нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр буурч 19.3 хувьд хүрлээ.
- Тайлант үед ойролцоогоор 100 төгрөг бүрийн зээлийн үйлчилгээнээс 19 төгрөгийн хүүгийн орлого олсон байна.
- Цэвэр орлогыг нийт орлогод харьцуулан тооцдог цэвэр ахиуц ашгийн харьцаа нь өмнөх оны мөн үеэс өсөлт үзүүлээгүй ба 17.1 хувь байна.



ЗАРДАЛ ОРЛОГЫН ХАРЬЦАА

- ХЗХ-дын 100.0 төгрөгийн орлого тутмын 24.0 төгрөг нь үйл ажиллагааны зардалд ногдож байна.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ХЗХ нь өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг дараах үндсэн 4 үзүүлэлт /PEARLS аргачлал/–ийн дагуу тооцож, мөрдлөг болгон ажилладаг. Үүнд:

1. Хөрөнгийн чанарын болон хамгаалалтын үзүүлэлт;
2. Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт;
3. Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлт;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт.



ХЗХ–ДЫН ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ

- Нийт чанаргүй зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 0.2 тэрбум төгрөгөөр буурч 7.8 тэрбум төгрөг боллоо.
- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.2 пунктээр буурч 3.6 хувьд хүрлээ. ХЗХ–дын мөрдөж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр энэхүү үзүүлэлт 5 хувиас бага байх ёстой.

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН АНГИЛАЛ

- Чанаргүй зээлийн ангилал дахь хэвийн бус зээлийн эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 4.8 пунктээр өсөж 33.5 хувь болжээ.
- Эргэлзээтэй зээлийн хувьд өнгөрсөн оны мөн үеэс 13.6 пунктээр буурч 14.3 хувьд хүрсэн бол муу зээл өнгөрсөн оны мөн үеэс 8.8 пунктээр өсөж 52.2 хувьд хүрсэн байна.



ХЗХ–ДЫН ХӨРВӨХ ЧАДВАР:

- ХЗХ–дын нийт мөнгөн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа тайлант улиралд 11.4 хувьтай байна.
- Богино хугацаат хөрөнгө оруулалт болон нийт зээлийн нийлбэрийг нийт хөрөнгөд харьцуулсан үзүүлэлт 81.1 хувьтай байна.





ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САН

- Тайлант үед ХЗХ–дын зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь 2.6 хувь; харин нийт хөрөнгөд эзлэх хувь 2.1 хувь байна.

Харьцаа	Зохистой хувь	Тайлант улиралд
Бусдаас авсан зээл/Нийт зээл	<20%	2.9%
Нийт хадгаламж/Нийт хөрөнгө	20%–80%	71.2%
Цэвэр зээл/Нийт хөрөнгө	60%–85%	78.9%
Хоршоологчдын өмч/Нийт хөрөнгө	>5%	11.2%
Нөөцийн сан/Хоршоологчдын өмч	>10%	36.5%
Хадгаламж хамгааллын сан/Хоршоологчдын өмч	>5%	8.7%
Тогтворжилтын сан/Хоршоологчдын өмч	>5%	8.7%
Үйл ажиллагааны зардал/Нийт хөрөнгө	<15%	4.0%

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн журмыг шинэчлэн батлахтай холбоотойгоор Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2022.09.20–ны өдрийн А/156 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл ажиллаж байна. Энэ хүрээнд "Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны нэгдсэн жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга бэлтгэх аргачлал"–ын төслийг боловсруулж МХЗХҮХ–оос санал авсан.
- Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан 2018 оны 274/А–256/541/59 дүгээр тушаалаар батлагдсан “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018–2023”–ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан банкнаас бусад санхүүгийн салбарын мэргэжлийн оролцогчийн ёс зүйн журмыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд мөрдөгдөх “Ёс зүйн дүрмийн үлгэрчилсэн загвар”–ын төслийг боловсруулж МХЗХҮХ–оос санал авсан.

ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022.04.29–ний өдрийн А–127 дугаар ажлын хэсэг байгуулах тухай тушаалаар байгуулагдсан "Банк, эрх бүхий байгууллагын мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасан “Зээл, хадгаламжийн хүүгийн аргачлал, мэдээллийн ил тод байдлын тухай журам боловсруулах" ажлын хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл ажиллаж байна.
- Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Жижиг дунд үйлдвэрлэлийн газрын хамтарсан Бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох сургалтын төлөвлөгөөний дагуу 2022.09.26–ны өдөр Сүхбаатар дүүрэг, 2022.09.29–ний өдөр Баянзүрх дүүргийн ЖДҮ–ийн эрхлэгчдийг хамруулан зохион байгуулсан сургалтад "Банк болон банкнаас бусад санхүүгийн байгууллага" сэдвээр мэдээлэл өгсөн.
- Зээлийн батлан даалтын сантай хамтран ХЗХ–дыг зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд хамруулах, бүтээгдэхүүний судалгаа хийх ажлын хүрээнд 2022.08.12–ны өдөр Төв аймагт үйл ажиллагаа эрхэлж байгаа хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаатай газар дээр нь танилцсан.

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Азийн Хөгжлийн Банк (АХБ)–ны "Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл"–ийг хариуцсан мэргэжилтний Монгол Улсад ажилласан томилолтын хүрээнд 2022.09.22–ны өдөр уулзаж төслийн хэрэгжилт, явцын талаар мэдээлэл өгсөн.
- Хадгаламж, зээлийн хоршооны зах зээлд 2022–2024 онд хэрэгжүүлэх Азийн Хөгжлийн Банк (АХБ)–ны TA–6883 MON: “Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө Зүүн Азийн жендерийн тэгш байдлыг эрчимжүүлэх төсөл"–ийн дэд хэсэг “Ногоон санхүүгийн хүртээмж, жендерийн тэгш байдлыг дэмжих төсөл”–ийн дотоодын зөвлөх ажиллаж эхэлсэн.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Нийт хөрөнгө

259.4

тэрбум төгрөг

Санхүүгийн зах зээлийн төлөв

Нэг батлан даалтын дундаж хэмжээ

352.5

сая төгрөг

Хүртээмжтэй байдал

Ирүүлсэн хүсэлтийн тоо **56**

Зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо **31**

Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа

Нийт орлого

7.5 тэрбум төгрөг

Нийт ашиг

4.5 тэрбум төгрөг

Тогтвортой байдал

Чанаргүй батлан даалтын эзлэх хувь

14.0%

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

Сангийн нийт хөрөнгийн хэмжээ 259.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар буюу 6.2 тэрбум төгрөгөөр, 2018 оны мөн үеэс 3.8 дахин буюу 190.3 тэрбум төгрөгөөр тус тус өслөө.

- Сангийн батлан даалтын үлдэгдэл 81.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар буюу 9.1 тэрбум төгрөгөөр буурлаа.
- Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 9.7 хувиар буюу 17.1 тэрбум төгрөгөөр буурч 159.4 тэрбум төгрөгт хүрлээ.





- 20.2 тэрбум төгрөгийн зээлд 10.6 тэрбум төгрөгийн 30 батлан даалтыг шинээр гаргасан нь өмнөх оны мөн үед гаргасан батлан даалтаас тооны хувьд 7.7 дахин, дүнгийн хувьд 3.1 дахин буурлаа.



ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

БАРУУН БҮС	ХАНГАЙН БҮС	ТӨВИЙН БҮС	ЗҮҮН БҮС
2 батлан даалт	2 батлан даалт	1 батлан даалт	1 батлан даалт
278.0 сая төгрөг	1,020.0 сая төгрөг	180.0 сая төгрөг	32.0 сая төгрөг
620.0 сая төгрөгийн зээл	2,700.0 сая төгрөгийн зээл	300.0 сая төгрөгийн зээл	80.0 сая төгрөгийн зээл

НИЙТ БАТЛАН ДААЛТЫН ХЭМЖЭЭ



- Улаанбаатар хотын хувьд нийт 9.1 тэрбум төгрөгийн 24 батлан даалт шинээр олгогджээ.



НЭГ БАТЛАН ДААЛТЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ

- Нэг батлан даалтын дундаж хэмжээний хувьд Улаанбаатар хотод 377.7 сая төгрөг, хөдөө орон нутагт 251.7 сая төгрөг, улсын хэмжээнд 352.5 сая төгрөг байна.
- Бүс нутгуудын хувьд хангайн бүсэд олгосон 1 батлан даалтын хэмжээ хамгийн их буюу 510.0 сая төгрөг байна.



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

	Батлан даалт гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийн тоо	Зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо	Эзлэх хувь
2019.III	151	85	56.3%
2020.III	100	53	53.0%
2021.III	319	236	74.0%
2022.III	56	31	55.4%

Батлан даалт гаргуулах нийт 56 хүсэлт ирснээс 31 хүсэлт нь зөвшөөрөгдсөн байна. Үүнээс 30 хүсэлтийн батлан даалтыг олгосон бөгөөд ирүүлсэн хүсэлтийн тоо нь өмнөх оны мөн үеэс 5.6 дахин, зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо 7.6 дахин буурсан байна. Хүсэлтийн зөвшөөрлийн хувь 55.4 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.6 пунктээр буурчээ.

Олгосон батлан даалтын 29.2 хувийг үйлдвэрлэлийн салбарт, 28.4 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 5.3 хувийг барилгын салбарт, 2.8 хувийг хөдөө аж ахуйн салбарт, 34.3 хувийг бусад салбарт тус тус гаргасан байна. Бөөний болон жижиглэн худалдааны салбарт гаргасан батлан даалтын эзлэх хувь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.9 пунктээр буурч, үйлдвэрлэлийн салбарт гаргасан батлан даалтын эзлэх хувь 10.8 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

- Гаргасан батлан даалтын дундаж хугацаа 88.9 сар буюу 7.4 жил байна.
- Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.5 сар буюу 3 жилээр буурсан үзүүлэлт юм.
- Тайлант улиралд харьцангуй урт хугацаатай цөөн тооны батлан даалт олгосон байна.

88.9 САР



Тайлант улиралд сангаас гаргасан батлан даалтын 50.3 хувийг Капитрон банк, 23.5 хувийг Хаан банк, 13.1 хувийг Голомт банк, 7.2 хувийг Төрийн банк, 4.7 хувийг Ариг банк, 0.9 хувийг Худалдаа хөгжлийн банк, 0.3 хувийг Транскапитал ББСБ–ын зээлд гаргасан батлан даалт тус тус бүрдүүлж байна.

АШИГТ АЖИЛЛАГАА

7.5
Тэрбум төгрөг
Нийт орлого
Өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар өссөн байна.

3.0
Тэрбум төгрөг
Нийт зарлага
Өмнөх оны мөн үеэс 2.7 дахин өссөн байна.

4.5
Тэрбум төгрөг
Цэвэр ашиг
Өмнөх оны мөн үеэс 27.4 хувиар буурсан байна.

Орлогын бүтэц

Сангийн хүүгийн орлого	92.72%
Батлан даалтын шимтгэлийн орлого	7.26%
Үйлчилгээний хураамжийн орлого	0.02%

Зарлагын бүтэц

Төсөл хэрэгжүүлсний зардал	47.5%
Цалин хөлсний зардал	34.2%
Ерөнхий удирдлагын бусад зардал	18.3%

Нийт хөрөнгийн өгөөж



Сангийн нийт хөрөнгийн өгөөж 1.8 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.6 пунктээр буурсан байна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

2022 оны 3 дугаар улирлын байдлаар чанаргүй батлан даалтын үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 3.7 тэрбум төгрөгөөр буюу 24.7 хувиар буурч 11.3 тэрбум төгрөгт хүрлээ.

Чанаргүй батлан даалтын үлдэгдэл
/тэрбум төгрөг/





Батлан даалтын нийт үлдэгдэлд эзлэх чанаргүй батлан даалтын хувь 13.9 болж өмнөх оны мөн үеэс 2.7 пунктээр буурлаа.

- Чанаргүй батлан даалтын үлдэгдлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 45.4 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, 20.5 хувь нь үйлчилгээний салбарт, 19.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 7.8 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 7.2 хувь нь барилгын салбарт олгосон батлан даалтууд бүрдүүлж байна.
- Жил ирэх тусам үйлдвэрлэлийн болон хөдөө аж ахуйн салбарын чанаргүй батлан даалтын эзлэх хувь багасаж байгаа бол бөөний болон жижигглэн худалдааны салбарын чанаргүй батлан даалт өссөн үзүүлэлттэй байна.



СЭНДБОКС
ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Хүсэлтийн тоо

15

Салбарын төлөв

Сэндбоксод туршигдаж буй бүтээгдэхүүнүүд

2

Бүтээгдэхүүн, үйлчилгээ

ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫ ТӨЛӨВ

Технологид суурилсан шинэ, шинэлэг санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг Зохицуулагч байгууллагын хяналт, зохицуулалт дор хязгаарлагдмал хүрээ, бодит орчинд, тодорхой цаг хугацаанд турших боломжийг олгож буй зохицуулалтын арга хэрэгсэл юм.

2021 оны 3 дугаар сарын 01-ний өдөр "Сэндбокс зохицуулалтын орчны журам" батлагдсан.

2021 оны 9 дүгээр сараас Сэндбоксод оролцох хүсэлтийг хүлээн авч эхэлсэн.

2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр "Сэндбоксын алба" байгуулагдсан.

Сэндбоксод туршигдаж буй бүтээгдэхүүнүүд

Цахим мөнгөнд суурилсан "Дижитал Бондын" үйлчилгээ



"Репо хэлцэл"-ийн платформын үйлчилгээ



ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ

Бүртгэгдсэн платформ

9

Салбарын төлөв

Анхдагч зах зээл дээрээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ

970.0 тэрбум төгрөг

Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Хүртээмжтэй байдал

9

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй платформ

Бодлого зохицуулалт

САЛБАРЫН ТӨЛӨВ

9

Нийт бүртгэсэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч

160

Арилжаалагдаж буй гадаад виртуал хөрөнгө

19

Арилжаалагдаж буй дотоод виртуал хөрөнгө

300

Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/

300,000

Хэрэглэгчдийн тоо

47%

Идэвхтэй хэрэглэгч

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 17–ны өдөр батлагдаж, 2022 оны 2 дугаар сарын 26–ны өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Тус хуулинд заасан “Шилжилтийн үеийн зохицуулалт”–аар хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс өмнө үйл ажиллагаа эрхэлж байсан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид 3 сарын дотор бүртгүүлэх хүсэлтээ гаргах үүрэг хүлээсэн. Тус хугацаа энэ оны 9 дүгээр сарын 26–ны өдөр дуусгавар болж нийт 9 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч холбогдох хууль, журамд заасан нөхцөл шаардлагыг хангаж бүртгэв.

24 ВХҮҮ

Хууль батлагдахаас өмнө үйл ажиллагаа явуулж байсан

9 ВХҮҮ

Шилжилтийн үеийн зохицуулалтаар нийт 13 хүсэлт ирүүлснээс 9 ВХҮҮ–ийг бүртгэсэн



15 ВХҮҮ

Үйл ажиллагааг зогсоож, улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн

МОНГОЛ УЛСЫН ВХҮҮ ХЭРЭГЛЭГЧ

~300,000
БҮРТГЭЛТЭЙ ХЭРЭГЛЭГЧ

140,000 ХЭРЭГЛЭГЧ ИДЭВХТЭЙ АРИЛЖАА ХИЙДЭГ

47%

179 койн/токен

160 гадаад

19 дотоод

ХУДАЛДАН АВАЛТ ХИЙХЭД ЧУХАЛЧИЛДАГ ЗҮЙЛС





ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ӨӨРЧЛӨЛТ /ӨДРӨӨР/



ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАР

Зохицуулалттай этгээд

295

Салбарын төлөв



ҮХХ–ийг зуучлан худалдан, худалдан авалт

927.5 тэрбум төгрөг

Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Хүртээмжтэй байдал

98.9%

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэгчид

Бодлого зохицуулалт

САЛБАРЫН ТӨЛӨВ

Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй **295**

2022 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 295 ҮХЭХЗ–ын байгууллага тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 68–аар өссөн үзүүлэлттэй байна.

Тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗ–ын байгууллагууд:

Брокер 309

Агент 1,413

Нэг ҮХЭХЗ–ын байгууллага дунджаар 1 брокер, 5 агенттай ажиллаж байна.

Хамгийн олон агенттай ҮХЭХЗ–ын байгууллагын агентын тоо 81 байна.

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗ–ын байгууллагуудын 446 хувьцаа эзэмшигчдийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 6.1 тэрбум төгрөг байна.

Агент



Брокер



ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮХЭХЗ-ЫН КОМПАНИУДЫН БАЙРШИЛ

СҮХБААТАР 85 | ХАН-УУЛ 78 | ЧИНГЭЛТЭЙ 35

БАЯНГОЛ 35 | БАЯНЗҮРХ 53 | СОНГИНОХАЙРХАН 6



БАЙРШИЛ

Нийт тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗ-ын байгууллагуудын 29 хувь нь Сүхбаатар, 26 хувь нь Хан-Уул, 18 хувь нь Баянзүрх, 12 хувь нь Чингэлтэй, 12 хувь нь Баянгол, 2 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт тус тус үйл ажиллагаа эрхэлж байгаа бол хөдөө, орон нутагт 3 ҮХЭХЗ-ын байгууллага буюу 1 хувь нь үйл ажиллагаа эрхэлж байна.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/

ШИГТГЭЭ

2022 оны 9 дүгээр сард хуучин орон сууцны 1 метр квадрат талбайн дүүргийн дундаж үнэ 3.1 сая төгрөг, Сүхбаатар дүүрэгт хамгийн өндөр буюу 3.7 сая төгрөг байгаа бол Сонгинохайрхан дүүрэгт хамгийн бага буюу 2.4 сая төгрөг байна.

Эх сурвалж: Монголбанкны орон сууцны үнийн мэдээлэл

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ, ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Давхардсан тоогоор ҮХЭХЗ–ын байгууллага нийт 5469 хэлцлээр, 1.4 сая м.кв талбай, 927.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан худалдан, шилжүүлжээ.

Шимтгэлийн хувь
/ Борлуулсан хэлцлийн тоогоор/



Талбайн хэмжээ
/Борлуулсан хэлцлийн тоогоор/*



ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ ХУДАЛДАА



** Шимтгэлийн хувь болон талбайн хэмжээний хэлцлийн тооны зөрүү нь 0 дүнтэй тоон мэдээллийг хасаж тооцсон болно.*

ТҮРЭЭСЛЭХ, ТҮРЭЭСЛҮҮЛЭХ, ХӨЛСЛӨХ, ХӨЛСЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Нийт 3,209 хэлцлээр 293 мянган м.кв талбай, 86.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан хөлслүүлж, түрээслүүлжээ.

Шимтгэлийн хэмжээ
/Түрээсэлсэн хэлцлийн тоогоор/*



Талбайн хэмжээ
/Түрээсэлсэн хэлцлийн тоогоор/*



Жич: 2022 оны 2 дугаар улирлаас түрээсийн шимтгэлийг гэрээний дүнгээс тооцох болсон.

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ ТҮРЭЭС



** Шимтгэлийн хувь болон талбайн хэмжээний хэлцлийн тооны зөрүү нь 0 дүнтэй тоон мэдээллийг хасаж тооцсон болно.*

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор батлсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”–ын шинэчилсэн найруулгын төсөлд “Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн нэгдсэн дээвэр холбоо” ГҮТББ болон тусгай зөвшөөрөлтэй 253 хуулийн этгээдээс санал авсан.

ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- “Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын бизнес эрхлэгчдийн нэгдсэн дээвэр холбоо” ГҮТББ, “ANR–Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын нэгдсэн холбоо” ГҮТББ, Үндэсний үл хөдлөх хөрөнгийн хөгжлийн нийгэмлэг болон Санхүүгийн боловсрол, сургалтын албатай хамтарсан уулзалтыг 2022 оны 9 дүгээр сарын 02–ны өдөр зохион байгуулж, үл хөдлөх хөрөнгө зуучлагчдыг мэргэшүүлэх, мэргэжлийн индексийг бий болгох, мөн мэргэжлийн эрх олгох сургалтыг сайжруулах хүрээнд санал солилцсон.
- Үндэсний үл хөдлөх хөрөнгийн хөгжлийн нийгэмлэг болон Санхүүгийн боловсрол, сургалтын албатай хамтарсан уулзалтыг 2022 оны 9 дүгээр сарын 07–ны өдөр зохион байгуулж, үл хөдлөх хөрөнгийн салбарын нэр томьёог бий болгох, үл хөдлөх хөрөнгө зуучлагчдыг мэргэшүүлэх сургалтыг сайжруулах боломжийн талаар санал солилцсон.

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАР

Арилжаа эрхлэгчдийн тоо

45 Хуулийн этгээд

456 Иргэн

Салбарын төлөв

Худалдан авсан үнэт металл

216.4

тэрбум төгрөг

Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Хүртээмжтэй байдал

79.8%

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй арилжаа эрхлэгч

Бодлого зохицуулалт

САЛБАРЫН ТӨЛӨВ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТОО:

Санхүүгийн зохицуулах хороо 2020 оны 5 дугаар сарын 06–ны өдрөөс үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож эхэлснээр нийт 45 хуулийн этгээд, 456 иргэн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна.

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД **45**

69 ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ ИРГЭД **136**

251 ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУГААР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ИРГЭД

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Тайлант улиралд тусгай зөвшөөрөлтэй 45 хуулийн этгээдийн 75 хувьцаа эзэмшигчдийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 9.4 тэрбум төгрөг байна.

Тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй нийт тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгч иргэдийн 364 буюу 79.8 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 92 буюу 20.2 хувь нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

Улаанбаатар хотод **79.8%**

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ /БАЙРШЛААР/



Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид ихэвчлэн хөдөө, орон нутагт, харин үнэт эдлэлийн арилжаа эрхлэгчид голчлон Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна. Тухайлбал үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн 57.3 хувь нь хөдөө, орон нутагт, 42.7 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

ӨМНӨГОВЬ 2
ДАРХАН–УУЛ 1
ГОВЬ–АЛТАЙ 2
ХЭНТИЙ 1
УВС 1

Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

ХОВД 2
ДАРХАН–УУЛ 4
БАЯНХОНГОР 1

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч

БАЯНХОНГОР 15
СЭЛЭНГЭ 21
ТӨВ 14
ДАРХАН–УУЛ 11
ГОВЬ–АЛТАЙ 3
ӨМНӨГОВЬ 6
УВС 2
ДОРНОГОВЬ 1
ӨВӨРХАНГАЙ 1
ХОВД 4

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ХУДАЛДАЖ, ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ МЕТАЛЛЫН ДҮН

Тайлант хугацаанд 1.2 тонн алтыг 216.3 тэрбум төгрөгөөр худалдан авч, 1.4 тонн алтыг 213.1 тэрбум төгрөгөөр борлуулсан нь өмнөх оны мөн үеэс худалдан авсан алтны хэмжээ 46.5 хувиар, худалдсан алтны хэмжээ 54.1 хувиар буурсан байна.

ҮНЭТ МЕТАЛЛ ЭРХЛЭГЧИД БОЛОН ИРГЭД, АЖ АХУЙ НЭГЖ ХООРОНДЫН АРИЛЖАА

ХУДАЛДАЖ, ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ДҮН

ХУДАЛДАЖ АВСАН ҮНИЙН ДҮН

Үнэт эдлэлийн борлуулалтын И–Баримтын мэдээгээр 2022 оны 3 дугаар улиралд давхардсан тоогоор 410 үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэн, хуулийн этгээд нь 6,651 харилцагчид 24,830 бүтээгдэхүүнийг 5.1 тэрбум төгрөгөөр худалдан борлуулсан байна.

ҮНЭТ МЕТАЛЛЫН БОРЛУУЛУЛТАЫН ДҮН



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Бичил уурхай эрхлэгчдийг албажуулах, алтны гарал үүслийг тодорхойлох, нийлүүлэлтийн сүлжээг ил тод болгох ажлын хүрээнд “The PlanetGold” төслийн Монгол Улс дахь суурин төлөөлөгчидтэй 2022 оны 9 дүгээр сарын 13–ны өдөр хамтарсан уулзалтыг зохион байгуулж, бичил уурхайн үйл ажиллагааг хариуцлагажуулах, бичил уурхайчдын амьжиргааны байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, сайн туршлага бий болгоход хамтран ажиллахаар санал солилцсон.
- Дархан–Уул аймаг болон Сэлэнгэ аймгуудад 2022 оны 10 дугаар сарын 13–ны өдрөөс 14–ний өдрүүдэд “Алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээтэй танилцах” үзлэг, хэлэлцүүлгийг “The PlanetGold” төсөл болон холбогдох төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2020.III	2021.III	2022.III
Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/	2,601.2	4,969.9	4,788.3
ЗЗҮ/ДНБ	7.0%	13.4%	11.1%
Хөрвөх чадвар	1.3%	3.7%	2.7%
Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/	34.9	186.1	150.4
Компанийн өрийн хэрэгслийн арилжаа /тэрбум төгрөг/	5.4	902.5	105.1
ЗГҮЦ-ны арилжаа /тэрбум төгрөг/	0.6	–	–
Хөрөнгө оруулалтын сан /тэрбум төгрөг/	–	54.4	3.2
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөг/	–	4.2	69.7
ТОП-20 индекс	17,531.6	42,937.3	34,024.3
MSE A индекс	8,218.9	13,972.5	12,098.5
MSE B индекс	7,558.5	12,270.5	11,972.2
ХК-ийн тоо	308	312	314
ҮЦК-ийн тоо	53	53	53
ХАА-н биржийн арилжааны дүн /тэрбум төгрөг/	472.2	672.1	1,034.2

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2020.III	2021.III	2022.II
Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/	390.7	444.6	449.6
Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж / тэрбум төгрөг/	163.4	192.0	219.8
Нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/	43.5	44.9	68.9
Нөөц сан /тэрбум төгрөг/	180.5	204.8	209.0
Давхар даатгалын хураамж /тэрбум төгрөг/	56.7	75.0	68.3
Цэвэр ашиг /тэрбум төгрөг/	17.1	21.3	14.1
Мэргэжлийн оролцогчид:			
Ердийн даатгал	15	15	15
Урт хугацааны даатгал	1	1	1
Давхар даатгал	1	1	1
Даатгалын төлөөлөгч	2,448	2,388	2,298
Даатгалын зуучлагч	54	56	62
Хохирол үнэлэгч	26	25	25
Актуарч	32	36	40
Аудитор	145	144	137
Аудитын компани	45	43	40

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	2020.III	2021.III	2022.III
Нийт хөрөнгө	**1,942.1**	**2,460.1**	**3,400.8**
Эргэлтийн хөрөнгө	**1,868.8**	**2,369.2**	**3,294.2**
Мөнгөн хөрөнгө	415.2	435.9	402.0
Богино хугацаат хөрөнгө оруулалт	9.6	19.1	16.0
Нийт зээл	1,357.8	1,765.9	2,666.1
Хэвийн зээл	1,177.8	1,568.7	2,360.3
Хугацаа хэтэрсэн зээл	52.1	50.3	111.0
Чанаргүй зээл	127.9	146.9	194.7
Зээлийн эрсдэлийн сан	94.1	117.0	142.1
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	10.9	12.4	19.7
Эргэлтийн бус хөрөнгө	**73.3**	**90.9**	**106.6**
Нийт өр төлбөр	**565.4**	**778.0**	**1,276.1**
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	141.9	216.5	354.0
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	206.5	219.1	407.2
Төслийн зээлийн санхүүжилт	21.3	15.2	19.4
Эзэмшигчдийн өмч	**1,376.6**	**1,682.1**	**2,124.7**
Хоёрдогч өглөг	0.8	45.3	70.5
Хувьцаат капитал	979.5	1,078.4	1,275.0
Хуримтлагдсан ашиг	362.5	504.1	714.9
ББСБ-ын тоо	**533**	**531**	**522**
Үүнээс: УБ хот	456	451	431
Хөдөө, орон нутаг	77	80	91
Харилцагчдын тоо	2,639,297	4,530,126	4,897,575
Нийт орлого	**303.9**	**354.2**	**624.8**
Хүүгийн орлого	247.2	282.5	500.6
Хүүгийн бус орлого	213.8	63.4	110.0
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	7.1	8.2	13.9
Нийт зардал	**189.3**	**206.4**	**389.8**
Хүүгийн зардал	33.4	30.3	68.6
Хүүгийн бус зардал	111.7	129.0	234.9
Болзошгүй эрсдэлийн зардал	30.4	29.3	51.9
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	2.6	2.9	4.9
Цэвэр ашиг	**114.7**	**147.8**	**235.0**

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	2019.III	2021.III	2022.III
Нийт хөрөнгө	**234.3**	**289.4**	**266.7**
Эргэлтийн хөрөнгө	230.1	278.0	262.5
Мөнгөн хөрөнгө	53.0	63.8	30.5
Авлага	8.6	9.8	19.3
Эргэлтийн бус хөрөнгө	4.1	11.4	4.1
Үндсэн хөрөнгө /цэврээр/	3.9	4.0	4.0
Биет бус хөрөнгө	0.2	7.4	0.2
Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0	0.0
Нийт зээл	**171.2**	**208.1**	**216.1**
Хэвийн зээл	159.1	194.5	203.0
Хугацаа хэтэрсэн зээл	4.8	5.6	5.2
Чанаргүй зээл	7.3	8.0	7.8
Өр төлбөр	**186.8**	**228.6**	**210.6**
Хадгаламж	163.6	203.8	189.8
Богино хугацаат зээл	2.6	2.9	2.6
Урт хугацаат өр төлбөр	6.6	6.0	3.7
Бусад богино хугацаат өр төлбөр	14.0	15.9	14.6
Өөрийн хөрөнгө	**47.5**	**60.8**	**56.1**
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	18.3	25.7	26.1
Хоршоологчдын өмч	29.0	34.8	29.9
Хуримтлагдсан орлого /алдагдал/	17.2	17.5	10.6
Нийт орлого	**39.3**	**41.8**	**44.0**
Хүүгийн орлого	37.6	38.9	41.7
Үйл ажиллагааны бусад орлого	0.7	0.9	0.7
Үйл ажиллагааны бус орлого	1.0	1.9	1.6
Нийт зарлага	**31.9**	**34.6**	**36.5**
Хүүгийн зардал	21.3	23.7	23.7
Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	1.3	1.5	1.4
Үйл ажиллагааны зардал	8.5	8.8	10.6
Үйл ажиллагааны бус зардал	0.1	0.1	0.1
Цэвэр орлого	**7.4**	**7.1**	**7.5**
ХЗХ–дын тоо	246	225	202
УБ ХЗХ–дын тоо	148	127	110
Орон нутаг ХЗХ–дын тоо	98	98	92
Гишүүдийн тоо	73,183	75,771	72,770

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

/Тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2020.III	2021.III	2022.III
Нийт хөрөнгө	113.2	253.2	259.4
Батлан даалтын үлдэгдэл	66.4	90.1	81.0
Үүнээс: Хугацаа хэтэрсэн	4.5	1.6	7.3
Чанаргүй	12.2	15.0	11.3
Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл	127.1	176.5	159.4
Үүнээс: Хугацаа хэтэрсэн	7.1	2.4	7.0
Чанаргүй	23.1	28.0	24.0
Үндсэн үйл ажиллагааны орлого	5.9	7.3	7.5
Үндсэн үйл ажиллагааны зардал	1.1	1.1	3.0
Үндсэн үйл ажиллагааны үр дүн	4.8	6.2	4.5
Олгосон батлан даалтын тоо	52	231	30
Үүнээс: Иргэдэд	0	0	0
Аж ахуйн нэгжид	52	231	30
Олгосон батлан даалтын дүн	10.8	32.4	10.6
Үүнээс: Иргэдэд	0.0	0.0	0.0
Аж ахуйн нэгжид	10.8	32.4	10.6
Үүнээс: Хөдөө аж ахуй	0.8	0.6	0.3
Үйлдвэрлэл	1.4	5.9	3.0
Бөөний болон жижиглэн худалдаа	5.0	19.2	3.0
Үйлчилгээ	3.5	3.5	3.6
Бусад	0.0	3.2	0.7
Батлан даалт гаргасан дундаж хугацаа /сараар/	95.6	43.2	88.9
Батлан даалт авахаар ирүүлсэн хүсэлтийн тоо	100	319	56
Үүнээс: Зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо	53	236	31

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2021.III	2022.III
ҮХЭХЗ–ын байгууллагын тоо	227	295
Брокерын тоо	248	309
Агентын тоо	1272	1413
Худалдаж, худалдан авч, шилжүүлсэн ҮХХ–ийн талбайн хэмжээ /м.кв/	759,219.2	1,387,194
Худалдаж, худалдан авч, шилжүүлсэн ҮХХ–ийн үнэ	613,949,000.7	927,483,570,184.9
Түрээслүүлж, түрээсэлж, хөлслүүлж, хөлсөлсөн ҮХХ–ийн талбайн хэмжээ /м.кв/	125,158.9	293,080.7
Түрээслүүлж, түрээсэлж, хөлслүүлж, хөлсөлсөн ҮХХ–ийн үнэ	13,332,328.1	86,142,685,749.5

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2021.III	2022.III
Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо	39	45
Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн тоо	65	69
Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэдийн тоо	235	251
Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэгч иргэдийн тоо	125	136
Худалдан авсан үнэт металлын бохир жин /грамм/	2,563,936.0	1,269,840.6
Худалдан авсан үнэт металлын нийт үнэ	404,152,102,899.0	212,922,943,643.5
Худалдсан үнэт металлын бохир жин /грамм/	3,011,461.2	1,485,406.6
Худалдсан үнэт металлын нийт үнэ	464,168,985,857.9	213,271,167,208.6
Худалдан авсан эдлэлийн нийт үнэ		1,881,355,713.0
Худалдсан эдлэлийн нийт үнэ	5,623,521,364.1	5,081,044,601.2

Засгийн газрын IV байр, Бага тойруу–3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160

+976–51–264444

press@frc.mn

www.frc.mn

Санхүүгийн зохицуулах хороо

@FRC_of_Mongolia